

СОНГУУЛИЙН ИРЦ (СОНГОГЧИЙН БҮРТГЭЛ)-ИЙН МЭДЭЭЛЛИЙГ ИЛ ТОД БОЛГОХ НЬ

Судалгааны тайлан

Энэхүү судалгааг АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн дэмжлэгтэйгээр Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд Лийд төгсөгчдийн холбоо хийж гүйцэтгэв. Судалгааны хүрээнд гарсан дүгнэлт, санал нь судлаачдын үзэл бодол бөгөөд АНУ-ын засгийн газар, эсвэл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.

Төслийн баг:

Н.Ганчимэг
О.Мөнгөнтуяа
Б.Батзаяа

Зөвлөх:

Э.Гэрэлт-Од, (PhD) Улс төр судлаач
П.Алтанчимэг, Судлаач
Ү.Амарбат, Хуульч, өмгөөлөгч

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

АГУУЛГА

ӨМНӨХ ҮГ.....	4
ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ.....	5
ТОВЧИЛСОН ҮГС.....	7
НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ.....	8
1.1 Судалгааны үндэслэл.....	8
1.2 Судалгааны зорилго.....	8
1.3 Судалгааны хамрах хүрээ.....	9
1.4 Судалгааны арга.....	9
ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН.....	10
2.1 Ерөнхий мэдээлэл.....	10
2.2 Сонгуулийн санал хураахаас өмнөх үе.....	13
2.3 Сонгуулийн санал хураалтын үе.....	21
2.4 Сонгуулийн санал хураалт дууссаны дараах үе.....	28
ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	38
ХАВСРАЛТ	41
ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ.....	49
АШИГЛАСАН МАТЕРИАЛ	50





ӨМНӨХ ҮГ

Лийд төгсөгчдийн холбоо нь ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлж, иргэн бүрийг тэгш хамруулсан, хүртээмжтэй нийгмийг цогцлоход хувь нэмрээ оруулах зорилготой “LEAD Mongolia” хөтөлбөрийн төгсөгчдийн үүсгэн байгуулсан төрийн бус байгууллага билээ.

Бид уг зорилгынхоо хүрээнд залуучуудын сонгуулийн талаарх ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, оролцоог сайжруулахаар хэд хэдэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлсний нэг нь Азийн сантай хамтран зохион байгуулсан “Сонгуулийн дата хакатон” юм. 2020 оны 5 дугаар сард болсон тус тэмцээнд 18-35 насны залуусыг хамруулсан бөгөөд сонгуультай холбоотой мэдээллийг ашиглан датад суурилсан бүтээл гаргах, түүгээрээ дамжуулан сонгуулийн талаарх залуусын ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх, сонгуулийн оролцоог сайжруулахад чиглэсэн.

Тэмцээний үр дүнд залуусын сонгуулийн идэвх, оролцоог нэмэгдүүлэх олон санал, санаачилга гарсны нэг нь **УИХ-ын сонгуулийн санал хураах өдөр насны ангилал бүхий сонгогчдын ирцийн мэдээллийг олон нийтэд шинэлэг хэлбэрээр шуурхай хүргэх, улмаар түүгээр дамжуулан залуучууд, сонгогчдыг сонгуульдаа идэвхтэй оролцохыг уриалах явдал** байлаа. Хакатоны тэргүүн байрын шагналт “2020” багийн гаргасан тус санааг бид Сонгуулийн Ерөнхий хороо, www.IKON.mn мэдээллийн сайттай хамтран ажил хэрэг болгож, 2020 оны УИХ-ын сонгуулийн санал хураах өдөр насны ангилал бүхий сонгогчдын ирцийн мэдээллийг Монголд анх удаа, олон нийтэд шинэлэг хэлбэрээр, шуурхай хүргэх ажлыг зохион байгуулсан юм.

Гэхдээ тус мэдээллийг 2020 оноос өмнөх сонгуулиудын ирцийн мэдээлэлтэй ижил түвшинд, нэг шалгуураар харьцуулах боломж үгүй байв. Учир нь **үе үеийн сонгуулийн ирцийн мэдээллийг насны ангиллаар, мөн тухайн насны бүлэгт харгалзах хувь хэмжээг нь тооцсон байдлаар гаргаж байсан тохиолдол байхгүй, мөн эдгээр мэдээлэл нь ил тод бус, олдож буй мэдээллийн эх сурвалж тодорхой биш** байв. Иймд энэ мэт тодорхойгүй байдлыг засаж сайжруулах, мэдээллийг ил тод, хэрэглэгдэхүйц болгох, мөн сонгогчдын ирц, идэвхийг нэмэгдүүлэх олон төрлийн кампанит ажлын үр дүнг хэмжих зорилгын дор ирцийн мэдээллийг ил тод болгох ажлыг эхлүүлэх нь зүйтэй гэж үзсэн билээ.

Улмаар судалгааны явцад зөвхөн ирцийн мэдээллийг ил тод болгох биш цаашлаад сонгогчийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах хэрэгцээ байгааг олж тогтоон, холбогдох санал зөвлөмжийг боловсруулаад байна.

Уг судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлсэн Азийн сан, үнэтэй цаг хугацаа, эрдэм мэдлэгээ зориулсан зөвлөх судлаачид болон хамтран ажилласан байгууллага, хувь хүмүүст талархал илэрхийлье. Судалгааны үр дүн, санал зөвлөмж нь Монгол Улсын сонгогчийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй болгоход хувь нэмрээ оруулна гэдэгт итгэлтэй байна.

Судалгааны тайлантай холбоотой асуулт, санал байвал leadalumniassociation@gmail.com цахим хаягаар холбогдох боломжтой.

Төслийн баг

ТАЙЛАНГИЙН ХУРААНГУЙ

2020 оны УИХ-ын сонгуулийн санал хураалтын өдөр Лийд төгсөгчдийн холбоо нь Сонгуулийн Ерөнхий хороо болон www.ikon.mn мэдээллийн сайттай хамтран сонгогчдын ирцийн мэдээллийг Монголд анх удаа, шинэлэг хэлбэрээр шуурхай хүргэх ажлыг амжилттай зохион байгуулсан. Газар зүйн байршил, насны ангилал, мөн тухайн насны бүлэгт харгалзах хувь хэмжээг харьцуулан гаргасан нь сонгуульд аль насны бүлгийнхэн хэрхэн оролцож буйг тооцоход томоохон алхам болсон юм. Гэвч тус мэдээллийг 2020 оноос өмнөх сонгуулиудын ирцийн мэдээлэлтэй ижил түвшинд, нэг шалгуураар харьцуулах боломж үгүй, түүнчлэн ирэх сонгуулиудын мэдээг ч уг хүртээмжит хэлбэрээр түгээх эсэх нь тодорхойгүй байв. Иймд ирцийн мэдээллийг ил тод болгох ажлын эхлэл болгож, уг судалгааны ажлыг хийж гүйцэтгэлээ.

Судалгааны явцад зөвхөн ирцийн мэдээллийг ил тод болгох биш цаашлаад сонгогчийн бүртгэлийн тогтолцоог сайжруулах хэрэгцээ байгааг олж тогтоосон. Иймээс “Сонгогчийн бүртгэл (сонгуулийн ирц)-ийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, ил тод, хүртээмжтэй болгох санал зөвлөмжийг гаргах” зорилгын дор судалгааны ажил явагдлаа. Судалгааны хүрээнд дараах асуултуудад хариулт өгөх байдлаар дүгнэлт, зөвлөмжийг гаргалаа. Үүнд,

1. Сонгогчийн бүртгэлийг бусад улс орнууд хэрхэн явуулдаг вэ? Монгол Улсад ямар хэлбэр нь тохирох вэ?

Монгол Улс сонгогчийн бүртгэлээ иргэний бүртгэлд үндэслэн, сонгуулийн үеэр сонгогчдын нэрийн жагсаалт гаргах нэг удаагийн шинж бүхий байдлаар явуулж байна. Энэ нь сонгогч сонгох эрхээ бүрэн дүүрэн эдлэх (нэрийн жагсаалтад бичигдэх) нөхцөлийг хангаж буй эсэх нь эргэлзээтэй, ил тод бус зэрэг сул талтай байна. Тиймээс шаардлагатай хууль, эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт оруулж сонгогчийн бүртгэлийн байнгын (тогтмол) тогтолцоог бий болгон, тогтмол шинэчлэгддэг байх жишигт шилжих нь сонгууль үнэн зөв, бодит бүртгэлд үндэслэн явагдах боломжийг бүрдүүлэх, сонгогчийн бүртгэлийн мэдээллийн сангийн ерөнхий мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй байршуулах боломжийг давхар бий болгох давуу талтай гэж үзэж байна.

2. Сонгогчийн бүртгэлийг эрхлэн явуулах (сонгогчдын нэрийн жагсаалт гаргах), ирцийг мэдээлэхтэй холбоотой харилцааг хууль, эрх зүйн баримт бичгүүдэд хэрхэн тусгасан байна вэ? Энэ нь тодорхой, хүртээмжтэй байж чадаж байна уу?

Сонгуулийн санал хураахаас өмнөх үе, санал хураалтын өдөр болон санал хураалт дууссаны дараах үеүдэд сонгогчийн ирц, бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг түгээх, нийтэд нээлттэй байршуулах үйл ажиллагааг зохицуулж буй хууль тогтоомж, дүрэм, журмуудад зарим харилцааг нарийвчлан тусгах шаардлагатай байна. Тухайлбал, сонгуулийн ирцийн мэдээг Улсын бүртгэлийн ерөнхий газар болон Сонгуулийн ерөнхий хороо нь өөр өөрийн нэгжээр дамжуулан авдаг, аль байгууллага нь мэдээг албан ёсоор нэгтгэх, зарлах, олон нийтэд түгээх тухай эрх зүйн зохицуулалт байдаггүй. Энэ нь сонгууль зохион байгуулахад оролцож буй байгууллагуудын чиг үүргийг давхардуулахгүй байх, зохицуулагдаагүй үлдсэн харилцааг аль нэг байгууллагад хуулиар үүрэг болгох шаардлагатайг харуулж байна. Сонгуулийн ерөнхий хороо сонгууль зохион байгуулах үндсэн чиг үүргээ хадгалах, Улсын бүртгэлийн ерөнхий газар нэрийн жагсаалт гаргах дээр нэмээд ирцийн мэдээг нэгтгэдэг, зарладаг, задгай тоон мэдээллийг Үндэсний статистикийн хороонд шилжүүлж, Мэдээллийн нэгдсэн санд багтаан олон нийтэд ил тод болгох ажлыг гүйцэтгэдэг байх нь тохиромжтой гэж үзэж байна. Түүнчлэн санал хураах өдөр сонгуулийн ирцийн мэдээг санал хурааж эхэлснээс хойш цаг бүрд олон нийтэд мэдээлж байх,



(Жишээлбэл сонгуулийн санал хураалт 8:00 цагт эхлэхэд ирцийн мэдээ 9:00 цагаас эхлээд цаг бүр гарч байх) техникийн боломжийг бүрдүүлэн ажиллах нь зүйтэй юм.

3. Сонгогчийн бүртгэл, ирцийг мэдээлж буй хэлбэр, загвар нь ил тод, хүртээмжтэй байж чадаж байна уу? Ил тод байршуулсан ирцийн мэдээлэл нь нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангаж чадаж байна уу? Тэдгээрт ямар дүн шинжилгээ хийх боломжтой байна вэ?

Сонгуулийн санал хураахаас өмнө иргэд өөрийн болон гэр бүлийн гишүүдийн, мөн өөрийн хаяг дээр бүртгэлтэй хүмүүсийн мэдээлэлтэй танилцах, санал хураалтын өдөр тойргийн хэмжээний ирцийн мэдээтэй танилцах, санал хураалт дууссанаас хойш ирцийн мэдээг нэгдсэн байдлаар авах боломжтой буюу энэ төрлийн мэдээлэл **харьцангуй ил тод** байна. Гэхдээ ирцийн мэдээлэл нь хэт ерөнхий, нас, хүйс, зарим тохиолдолд газар зүйн байршил зэргээр нарийвчлан дүн шинжилгээ хийх боломжгүй, статистикийн бусад мэдээлэлтэй ижил түвшинд харьцуулах боломжгүй, **хүртээмжгүй, нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангаж чадахгүй байна.**

Иймээс,

- ▶ Сонгуулийн өмнө улсын хэмжээнд болон тойрог бүрд сонгуулийн эрхтэй сонгогчдын тоо, насны бүлэг, хүйс болон газар зүйн байршлаар (эсвэл засаг захиргааны нэгжээр) мэдээлж байх,
- ▶ Сонгогчдын насны бүлгийг одоо байгаа 18-25, 26-40, 41-55, 56-с дээш гэсэн өргөн хүрээнд бус 18-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-44, 45-49, 50-54, 55-59, 60-64, 65-69, 70-с дээш гэсэн аль болох бага алхмаар тодорхойлох. Ингэснээр сонгогчийн сонгуулийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, оролцоог сайжруулах оновчтой төлөвлөлт, шийдэл гаргах, ҮСХ-ны статистикийн бусад үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжтой болно.
- ▶ Эдгээр мэдээллээ дахин боловсруулах боломжтой, нээлттэй өгөгдлийн форматаар байрлуулах, мөн тогтсон хугацаанд (сонгуулийн бус жилд нэг удаа, сонгуулийн жилд сонгууль зохион байгуулагдахаас өмнө) тогтмол шинэчлэгдэх, үнэн зөв, бүрэн гүйцэд байх шаардлагыг хангах зэрэг болно.

2020 оны 10 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сарыг дуустал үргэлжилсэн тус судалгааны хүрээнд 1992 оноос 2020 оныг дуустал хугацаанд явагдсан сонгуулиудын сонгогчдын ирцийн мэдээлэлд болон хүчин төгөлдөр үйлчилж буй сонгогчийн бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудад дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ баримт бичгийн болон хууль эрх зүйн харьцуулсан шинжилгээний аргуудыг ашиглалаа.

ОИХ.МН
СУДАЛГААНЫ САН

ТОВЧИЛСОН ҮГС

АИХЭГ	Ардчилсан институт, хүний эрхийн газар
АНСДИТХСТХ	Аймаг нийслэл, сум дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль
БХЯ	Батлан хамгаалах яам
ГИХГ	Гадаадын иргэн харьяатын газар
ЕАБХАБ	Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУИХСТХ	Монгол Улсын Их хурлын сонгуулийн тухай хууль
МУЕСТХ	Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
СНЖ	Сонгогчдын нэрийн жагсаалт
УБЕГ	Улсын Бүртгэлийн ерөнхий газар
УДШ	Улсын Дээд шүүх
УИХ	Улсын Их Хурал
ҮСХ	Үндэсний статистикийн хороо
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

НЭГ. СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ

Сонгууль бол санал хураалт явуулах замаар улс төрийн шийдвэр гаргах үйл явц. Сонгуульд хууль ёсны эрх бүхий сонгогч оролцож саналаа өгөх эрхтэй. Сонгогчийг бүртгэх, бүртгэлийг танилцуулах, тус бүртгэлд тулгуурласан сонгогчдын ирцийг мэдээлэх, баталгаажуулах ажил нь иргэдийн сонгох эрхийг хамгаалж буй үйл ажиллагаа болдог.

Гэвч дээрх үйл ажиллагаа нь ил тод, хүртээмжтэй бус байгаа нь мэдээллийн ил тод байдлыг хангах, мэдээлэл авах эрхийг зөрчсөн, сонгогчдыг төөрөгдүүлсэн, энэ чиглэлийн судалгаа шинжилгээний ажлыг хийхэд хүндрэл учруулсан хэрэг болж байна.¹

Уг нөхцөл байдал нь улмаар иргэд, улс төрчид сонгогчийн бүртгэлд итгэдэггүй², өрсөлдөгч намууд харддаг³, сонгогчдыг улс төрийн зорилгоор шилжүүлдэг (2016 онд нийт 18307 сонгогч шилжиж явсны 41 хувь УИХ-ын дөрвөн тойрогт очсон)⁴, санаатай болон санамсаргүй сонгох эрхийг хязгаарладаг, улмаар сонгуулийн дүнд итгэхгүй байх зэрэг сөрөг үр дагаврыг дагуулж байна.

Иймээс Монгол Улс дахь сонгогчийн бүртгэл (сонгогчдын нэрийн жагсаалт), сонгуулийн ирцийн ил тод байдал, эдгээрийн эрх зүйн зохицуулалт бүрдсэн эсэх, практикт хэрхэн шийдэж ирсэн, цаашид авах арга хэмжээний боломж зэргийг судлах зайлшгүй шаардлагатайг өгүүлж байна.

1.2 СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Сонгогчийн бүртгэл (сонгуулийн ирц)-ийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийж, ил тод, хүртээмжтэй болгох загвар бүхий санал зөвлөмжийг гаргахад судалгааны зорилго оршиж байв.

Дээрх зорилгын хүрээнд дараах судалгааны асуултуудыг дэвшүүлж ажиллалаа. Үүнд,

1. Сонгогчийн бүртгэлийг бусад улс орнууд хэрхэн явуулдаг вэ? Монгол Улсад ямар хэлбэр нь тохирох вэ?
2. Сонгогчийн бүртгэлийг эрхлэн явуулах (сонгогчдын нэрийн жагсаалт гаргах), ирцийг мэдээлэхтэй холбоотой харилцааг хууль, эрх зүйн баримт бичгүүдэд хэрхэн тусгасан байна вэ? Энэ нь тодорхой, хүртээмжтэй байж чадаж байна уу? Ингэхдээ сонгуулийн санал хураалтын өмнө, санал хураалтын үед болон санал хураалтын дараа гэсэн цаг хугацааны үечлэлээр судаллаа.
3. Сонгогчийн бүртгэлийг гаргах (сонгогчдын нэрийн жагсаалт)-ад оролцдог байгууллагуудын чиг үүрэг, үйл ажиллагаа хоорондоо уялдаатай байж чадаж байна уу?
4. Сонгогчийн бүртгэл, ирцийг мэдээлж буй хэлбэр, загвар нь ил тод, хүртээмжтэй байж чадаж байна уу? Ил тод байршуулсан ирцийн мэдээлэл нь нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангаж чадаж байна уу? Тэдгээрт ямар дүн шинжилгээ хийх боломжтой байна вэ? зэрэг асуултад хариулт өгөх замаар Монгол Улс сонгогчийн бүртгэлийн тогтолцоог боловсронгуй, ил тод, хүртээмжтэй болгохын тулд ямар алхмуудыг зайлшгүй авч хэрэгжүүлбэл зохистой талаар бодлогын зөвлөмж гаргалаа.

¹“Сонгуулийн дата хакатон”-д оролцогчдод хамгийн их тулгамдаж байсан асуудал нь сонгуультай холбоотой аливаа тоон мэдээллийг нээлттэй эх сурвалжаас, хүртээмжит хэлбэрээр авах боломж хязгаарлагдмал байсан явдал байв.

²Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар ямар ч буруугүй. УБЕГ-ын мэдээлэл. 2012-6-25 <http://www.assa.mn/a/3717>

³Ардчилсан нам ард түмний саналыг хамгаалж чадсангүй. Өдрийн сонин. 2012.12.04. <https://dnn.mn/archive/31666/>

⁴Монгол улсын их хурлын сонгууль 2016 оны 6-р сарын 29-ний өдөр ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны тайлан <https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>

1.3 СУДАЛГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

Цаг хугацааны тухайд:

1992 оноос 2020 оныг дуустал хугацаанд явагдсан Улсын Их Хурлын, Ерөнхийлөгчийн болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын ирцийн мэдээлэлд дүн шинжилгээ хийлээ. Мөн 2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй сонгогчийн бүртгэлтэй холбоотой харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн актуудыг хамруулсан.

Судалгааны мэдээлэл бүрдүүлэх ажил 2020 оны 10 дугаар сараас 2021 оны 1 дүгээр сарыг дуустал үргэлжиллээ.

Агуулгын тухайд:

Сонгуулийн ирцийн мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгох нь зөвхөн санал хураалтын явц дахь сонгогчдын ирцийн мэдээллийг хамрах бус харин сонгогчийн бүртгэл гаргахаас эхлээд тус бүртгэлд тулгуурласан ирцийн мэдээг танилцуулах ажиллагааг хамарсан сонгуулийн бүтэн мөчлөг, тогтолцоогоор нь авч үзэх нь судлагдахууны хувьд ач холбогдолтой гэж үзлээ. Иймээс,

1. Сонгуулийн санал хураахаас өмнөх үе (сонгогчийн бүртгэл/нэрийн жагсаалт гаргах, нягтлах, зөрчлийг арилгах, шинэчлэх, танилцуулах үйл явцууд хамаарна)
2. Сонгуулийн санал хураалтын үе (сонгогчийн бүртгэл/нэрийн жагсаалт-г нягтлах, сонгогчийг бүртгэх, ирцийг мэдээлэх)
3. Сонгуулийн санал хураалт дууссаны дараах үе (ирцийг баталгаажуулах, мэдээлэх) гэсэн үе шатуудын хүрээнд ирцийн мэдээллийг ил тод, хүртээмжтэй болгоход холбогдох үйл явцыг хамруулан судаллаа.

1.4 СУДАЛГААНЫ АРГА

Судалгаанд баримт бичгийн болон хууль эрх зүйн харьцуулсан шинжилгээний аргуудыг ашиглалаа. Ингэхдээ сонгуулийн санал хураахаас өмнөх үе, санал хураалтын өдөр, санал хураалт дууссаны дараах үе тус бүрд

- Хууль, эрх зүйн зохицуулалтын тодорхой байдал
- Байгууллага хоорондын уялдаа
- Сонгогчийн бүртгэл/ирцийн мэдээллийн ил тод байдал
- Сонгогчийн бүртгэл/ирцийн мэдээллийн хүртээмж зэрэг үндсэн шалгуур үзүүлэлтүүдийг “Хангалттай”, “Сайжруулах шаардлагатай” гэсэн үнэлгээгээр дүгнэлээ.

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

ХОЁР. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

2.1 ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- 1992 оноос 2020 оныг дуустал Монгол Улсын хэмжээнд УИХ-ын 8 удаагийн ээлжит сонгууль, Ерөнхийлөгчийн 7 удаагийн ээлжит сонгууль, Орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 8 удаагийн ээлжит сонгууль⁵ тус тус болж өнгөрчээ.
- Сонгууль зохион байгуулах үүрэгтэй төрийн байгууллага нь Сонгуулийн ерөнхий хороо (СЕХ) бөгөөд сонгууль бэлтгэн явуулах ажлыг төлөвлөх, зохион байгуулах бүрэн эрхийг хэрэгжүүлдэг.⁶ Иргэний бүртгэл хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) нь сонгогчийн бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үндэслэн хөтөлдөг буюу биеийн давхцахгүй өгөгдлийн (гарын хурууны хээ) бүртгэлд бүртгүүлсэн, 18 нас хүрсэн иргэнийг сонгогчийн бүртгэлд бүртгэдэг.⁷
- 2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар Монгол Улсын сонгуулийн эрх зүйн харилцааг зохицуулсан, хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 7 хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан 15 хэм хэмжээний акт (журам) байна. Дээрх сонгуулийн харилцааг бүхэлд нь зохицуулж буй хууль тогтоомж болон холбогдох хэм хэмжээний актуудаас судалгааны зорилгын хүрээнд судлахыг зорьж буй харилцааг тусгайлан зохицуулсан хууль нь одоо хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль (МУЕСТХ), Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль (МУИХСТХ), Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай хууль (АНСДИТХСТХ) болон тэдгээрт нийцүүлэн гаргасан (УБЕГ-ын даргын А/372, А/961 тоот тушаал, СЕХ-ны 46 тоот тогтоол) журмууд байна.
- Монгол Улсын тухайд иргэний бүртгэл хариуцсан төрийн захиргааны төв байгууллага болох УБЕГ сонгогчийн бүртгэлийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн санг үндэслэн хөтөлдөг. Өөрөөр хэлбэл биеийн давхцахгүй өгөгдлийн (гарын хурууны хээ) бүртгэлд бүртгүүлсэн, 18 нас хүрсэн иргэнийг сонгогчийн бүртгэлд бүртгэх хуультай.⁹ Мөн сонгуулийн үеэр сонгогчдын нэрийн жагсаалт гаргах байдлаар ажилладаг. Эндээс дүгнэвэл **Монгол Улс сонгогчийн бүртгэлийн тогтолцооны “иргэний бүртгэлд үндэслэсэн” хийгээд “сонгуулийн үед сонгогчдын жагсаалт гаргадаг” хэв шинжийг хадгалсан** байна. Дэлхийн бусад орнууд сонгогчийн бүртгэлийг хэрхэн гаргадаг талаар доорх эшлэлээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Дэлхийн улс орнуудад сонгогчийг бүртгэж, нэрийн жагсаалт гаргахдаа сонгуулийн үеийн (periodic list), байнгын (continuous list), иргэний бүртгэл (civil registry) гэсэн гурван тогтолцоонд үндэслэдэг аж. Тогтолцоо бүр давуу болон сул талтай. Улс орнууд өөрийн нөхцөл байдалдаа тохирсон хамгийн тохиромжтой тогтолцоог сонгох нь чухал гэж үздэг.

1. Сонгуулийн үеийн бүртгэл буюу сонгуулийн үед сонгогчдын жагсаалт гаргах тогтолцоо нь олон талаараа хамгийн энгийн байдаг. Сонгууль бүрд сонгуулийн эрх бүхий сонгогчдын нэрийн

⁵ Сонгууль. Үндэсний статистикийн хороо. www.1212.mn

⁶ Сонгуулийн төв байгууллагын тухай хууль. 2006 он. <https://legalinfo.mn/law/details/459?lawid=459>

⁷ Иргэний улсын бүртгэлийн тухай хууль. 2018 он. <https://www.legalinfo.mn/law/details/13540?lawid=13540>

⁸ Хууль, журмын жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү.

⁹ Иргэний улсын бүртгэлийн тухай хууль. 2018 он. <https://www.legalinfo.mn/law/details/13540?lawid=13540>

жагсаалтыг шинэчилж гаргадаг. Төрийн эрх бүхий байгууллагын хүчин чармайлт, түр зуурын ажилтнуудын оролцоонд тулгуурлаж энэ ажлыг зохион байгуулдаг. Энэ тогтолцоог Гана, Малави, Либерид улсад ашигладаг.

2. Байнгын бүртгэлийн тогтолцоо нь өмнөх бүртгэлд үндэслэн жагсаалтыг тогтмол шинэчлэн хадгалах зорилготой тасралтгүй үргэлжилдэг тогтолцоо юм. Энэ тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд сонгуулийн мөчлөгийн туршид төрийн эрх бүхий байгууллага сонгогчийн бүртгэлийг байнга хариуцаж, шинэчилж ажиллахыг шаарддаг. Сонгогчийн бүртгэлийг шинэчлэхдээ хүн амын өөрчлөлтийг хянах бөгөөд шаардлагатай мэдээллийг олж авахын тулд эрх бүхий байгууллагууд, үүнд цагдаа, татвар, шуудан зэрэг бусад төрийн байгууллагуудтай мэдээлэл солилцдог. Аргентин, Австрали, Канад, Франц, Алжир, Буркина Фасо, Чад, Танзани, Мозамбик зэрэг улсууд энэ системийг хэрэглэдэг бөгөөд иргэн бүрд иргэний таних дугаарыг олгож, байгууллагууд өгөгдөл хуваалцах замаар сонгогчийн бүртгэлийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлдэг.
3. Иргэний бүртгэл нь иргэний таних дугаар, төрсөн он сар өдөр, хаяг, хүйс зэрэг иргэдийн нэр, бусад таних шинж чанарыг багтаасан хүн амын бүртгэл юм. Иргэний бүртгэлийг олон янзын зорилгоор ашигладаг. Үүний нэг нь сонгуульд оролцох сонгогчдын нэрийн жагсаалтыг гаргах явдал. Сонгууль зохион байгуулах байгууллага нь сонгогчдын нэрийн жагсаалтыг шинэчлэхэд маш бага үүрэг гүйцэтгэдэг эсвэл огт оролцдоггүй бөгөөд энэ мэдээллийн санг иргэний бүртгэл хариуцсан байгууллагаас авдаг. Энэ нь хариуцлага, хяналтыг сулруулдаг сул талтай. Дани, Герман, Финлянд зэрэг улсууд энэ тогтолцоог хэрэглэдэг.¹⁰

- Сонгогчийн бүртгэл болон ирцийн мэдээллийг хариуцсан төрийн байгууллагууд нь ил тод мэдээлж байгаа эсэх, ил тод байгаа мэдээлэл нь нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангаж байгаа эсэх нь судлагдахууны хувьд сонирхолтой, ач холбогдолтой юм. Төрийн байгууллага өөрт цуглуулж, нягтлан шалгасан өгөгдлийг төрийн болон төрийн бус байгууллага, иргэний нийгмийн байгууллага зэрэг оролцогч талуудыг үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллээр хангах зорилгоор нээлттэй өгөгдөл хэлбэрээр байршуулдаг. Монгол Улсад төрийн өгөгдөл, мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах хууль, эрх зүйн баримт бичиг үйлчилж байна. Эдгээр нь,
 - Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.4 мэдээллийн хүртээмжтэй байдал¹¹
 - Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль¹²
 - Шилэн дансны тухай хууль¹³
 - Төрөөс нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл (2019) зэрэг болно.
- Ийнхүү хууль, эрх зүйн орчин бүрдсэн бөгөөд **олон нийт сонгогчийн бүртгэлийн болон ирцийн мэдээллийг нээлттэй өгөгдлийн шалгуурт нийцсэн хэлбэрээр авах эрхтэй, нөгөө талаас СЕХ, УБЕГ мэдээллээ ийм хэлбэрээр өгөх үүрэгтэй** нь харагдаж байна. (Монгол Улсад нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх үйл явц хэрхэн явагдаж буй, олон улсад хэрхэн хэрэгжиж буй талаарх мэдээллийг Хавсралт 2-оос үзнэ үү)

¹⁰ Voter registration. ACE project <https://aceproject.org/ace-en/topics/vr/vra/vra01>


¹¹ Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал. 2010 он. <http://www.nsc.gov.mn/sites/default/files/National%20Security%20Concept%20of%20Mongolia%20MN.pdf>

¹² Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль 2011 он. <https://www.legalinfo.mn/law/details/374>

¹³ Шилэн дансны тухай хууль. 2014 он. <https://www.legalinfo.mn/law/details/10497>

Төрөөс олон нийтэд нээлттэй өгөгдлийг түгээх байдлаар нь “таван одны схем”-ээр дүгнэдэг. 1 од нь цахим хуудсаар нийтэлж буй бичвэр, график, эсвэл PDF файл форматаар татаж авах боломжтой байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн өгөгдөл дээр боловсруулалт хийх боломжгүй. Харин 2 ба түүнээс дээш одтой өгөгдөл нь боловсруулалт хийх, дахин ашиглах боломжтой нээлттэй өгөгдөл. Одны тоо нэмэгдэх тусам тухайн өгөгдөл дээр оролцогч талууд олон төрлийн боловсруулалтыг шууд хийх боломжтой байдаг. Энэ схемийн дагуу сонгуулийн ирцийн мэдээллийг үнэллээ.

Зураг 1. Нээлттэй өгөгдлийг түгээх таван одны схем¹⁴



¹⁴ <https://5stardata.info/en/>

2.2 СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААХААС ӨМНӨХ ҮЕ

Үр дүнгийн хураангуй

Сонгогчийн бүртгэл / нэрийн жагсаалт гаргах хууль, эрх зүйн зохицуулалт тодорхой байгаа тул ХАНГАЛТТАЙ хэмээн үнэллээ.

- Сонгогчийн бүртгэл / нэрийн жагсаалт гаргах нь иргэдийн сонгох эрхийг баталгаажуулж буй үйл явц бөгөөд энэхүү эрхээ эдэлсэн байдал нь сонгуулийн ирцээр илэрхийлэгддэг.
- Сонгогчийн бүртгэл / нэрийн жагсаалт гаргах үйл ажиллагааг МУИХСтХ, АНСДИТХСтХ болон МУЕСТХ, эдгээрт нийцүүлэн гаргасан УБЕГ-ын даргын тушаал бүхий журмын хүрээнд зохицуулж байна.
- Сонгуулийн санал хураалт болох өдрөөс 2-4 сарын өмнө сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам, маягт, загварыг батлах зэрэг үйл ажиллагаа явагддаг бөгөөд УБЕГ хариуцдаг.

Сонгогчийн бүртгэл/нэрийн жагсаалт гаргах явцын ил тод байдлыг САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.

- УБЕГ-аас сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоог зарладаг ч сонгуулийн насны нийт иргэдийн тоог, нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоог зарладаггүй. Сонгуулийн насны иргэдийн тоон өөрчлөлттэй нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоон өөрчлөлт уялдаггүй, зөрүүтэй байдаг.
- УДШ, БХЯ, ШШГЕГ, ЦЕГ, ХХЕГ, ГИХГ зэрэг төрийн байгууллагуудаас СЕХ-оор дамжин УБЕГ-т очдог сонгуулийн эрхээ хязгаарлуулсан иргэдийн тоо, мэдээлэл ил тод биш байдаг.
- Гадаадад 6 сараас дээш хугацаагаар албан болон хувийн ажлаар ажиллаж, амьдарч байгаа сонгогчийн бүртгэл (нас, хүйс, байршлын талаарх) мэдээлэл тодорхой бус, ил тод биш байгаа нь тэдний саналаа өгөх эрхийг зөрчиж буй хэрэг болно.

Сонгогчийн бүртгэл/нэрийн жагсаалттай танилцах боломж НЭЭЛТТЭЙ боловч ХЯЗГААРЛАГДМАЛ.

- Сонгогчид өөрийн мэдээлэлтэй сонгууль болохоос 86-90 хоногийн өмнөөс эхлэн УБЕГ-ын веб сайтаас цахимаар болон сонгуулийн хэсгийн хороон дээр очиж танилцах боломжтой байдаг. Хэсгийн хороон дээрх цаасан суурьтай бүртгэлээс гэр бүлийн гишүүдийн тухай мэдээлэл болон өөрийн хаяг дээр бүртгэлтэй байгаа хүмүүсийн мэдээлэлтэй танилцах боломжтой.
- Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нь сонгогчдын нэрийн жагсаалтын холбогдох хэсгийг санал авах өдрөөс 2 болон 20-иос доошгүй хоногийн өмнө, цахим хэлбэрээр нэг удаа авах боломжтой. Өөрөөр хэлбэл сонгогчийн мэдээлэлтэй хязгаарлагдмал байдлаар танилцах боломжтой байдаг.

Дэлгэрэнгүй дүн

Дээр дурдсан үйл ажиллагаа хэрхэн явагддаг, тэдгээрийн хууль, эрх зүйн зохицуулалт хийгээд ил тод, хүртээмжтэй байдалд хийсэн үнэлгээг дэлгэрүүлэн авч үзье.

Сонгогчийн бүртгэл / нэрийн жагсаалт гаргах болон түүнтэй уялдсан бусад үйл ажиллагааг хууль эрх зүйн хүрээнд хэрхэн зохицуулсан бэ?

МУИХСтХ (2019 онд батлагдсан), АНСДИТХСтХ (2020 онд батлагдсан)-д заасанчлан сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэний улсын бүртгэлийн цахим бүртгэлийн мэдээллийн санд үндэслэн үйлдэх, түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, холбогдох бүртгэлийг хийх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага буюу Улсын бүртгэлийн ерөнхий газар зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаг. Харин 2020.12.24-ний өдөр батлагдсан МУЕСтХ-д УБЕГ нь дээрх үйл ажиллагааг буюу сонгуулийн үед сонгогчдын ирцтэй холбоотой гарсан бүхий л асуудлыг өөрийн эрх хэмжээний хүрээнд, мөн СЕХ-той хамтран явуулахаар тусгагджээ.

Хүснэгт 1. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах тухай журам батлах хуулийн зохицуулалтууд

МУИХСтХ-н 20.16 дахь хэсэг	АНСДИТХСтХ-н 20.15 дахь хэсэг	МУЕСтХ-н 19.17 дахь хэсэг
Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах, сонгогч шилжих журам болон маягт, загварыг энэ хуульд нийцүүлэн баталж мөрдүүлнэ.	Улсын бүртгэлийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах журам болон маягт, загварыг энэ хуульд нийцүүлэн батална.	Улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах журам болон маягт, загварыг Сонгуулийн ерөнхий хороотой хамтран батална.

УБЕГ нь Монгол Улсын Их Хурлын Сонгууль зохион байгуулахаас өмнө буюу 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдөр хуулийн дээрх заалтад холбогдуулан УБЕГ-ын даргын **А/372 тушаалаар**¹⁵ Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үед сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам холбогдох бусад маягтуудыг тус тус баталсан байна. Мөн АНСДИТХСтХ-н 20.15 дахь заалтад холбогдуулан Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам, холбогдох бусад маягтуудыг УБЕГ-ын даргын **А/961 тоот тушаалаар**¹⁶ баталсан байна. (2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн холбогдох заалтад хамаарах тушаал хараахан гараагүй)

¹⁵ Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам /УБЕГ-ын даргын А/372 дугаар тушаал/ /2020.03.24/ <https://burtgel.gov.mn/post/43795>

¹⁶ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам /УБЕГ А961/ <https://burtgel.gov.mn/post/43958>

Эдгээр журамд тусгагдсан харилцааг тоймлон харуулбал,

1. Сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрийг тодорхой болгоно. (Сонгуулийн төрлөөс шалтгаална)
2. Сонгуулийн тухайн хэсгийн нутаг дэвсгэрт хамаарах (Жишээлбэл 1 дүгээр тойргийн 1 дүгээр хэсгийн нутаг дэвсгэрт хамаарах) сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэх ёстой сонгуулийн насны иргэдийн мэдээллийг улсын бүртгэлийн цахим мэдээллийн санд оруулна.
3. Нэрийн жагсаалт үнэн зөв, бүрэн тусгагдсан эсэх, шилжилт хөдөлгөөнийг тусгасан эсэх, нас барсан, харьяатаас гарсныг бүртгэсэн эсэх болон давхардаагүй эсэхийг нягтлан шалгаж, гарсан зөрчлийг арилгах арга хэмжээ авна.
4. Сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас хүйс, регистрийн дугаар, байнга оршин суугаа хаяг гэсэн дарааллаар нэрийн жагсаалтыг үйлдэнэ.
5. Сонгогчдын нэрийн жагсаалтыг сонгуулиас өмнө тодорхой хугацаанаас эхлэн (МУИХС-с 86 хоног, АНСДИТС-с 90 хоног) сонгууль дуустал УБЕГ-ын цахим хуудсанд байршуулна.
6. Сонгогчдын нэрийн жагсаалтыг (СНЖ) цахим хуудаст байршуулахдаа тухайн сонгогчийг СНЖ дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжоор хангана.
7. Сонгогчдын нэрийн жагсаалтад оруулах өөрчлөлтийг санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө цахим санд тусгаж, хувийг сонгуулийн хэсгийн хороо, итгэмжлэгдсэн ажилтан, Улсын бүртгэлийн хэлтэст тус тус өгөх зэрэг болно.¹⁷

Дээрхээс үзвэл, УИХ-ын болон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн үед сонгогчдын нэрийн жагсаалтыг иргэдэд сонгуулийн санал авах өдрөөс 86-90 доошгүй хоногийн өмнө үйлдэж, сонгогчдод өөрийн мэдээлэлтэй танилцах боломжийг уг журмаар нарийвчлан зохицуулсан, мөн сонгогчийн бүртгэл, өөрчлөлтийг ямар тохиолдолд хийх, сонгогчийн бүртгэлтэй холбоотой гомдол, маргааныг хэрхэн шийдвэрлэх болон холбогдох бусад харилцааг нарийвчлан зохицуулсан байна.

Сонгогчийн бүртгэл үйлдэх / сонгогчдын нэрийн жагсаалт гаргах үйл явц нь сонгогчийн сонгох эрхийг хангаж чадаж байна уу?

Монгол Улсын Үндсэн хуулийн 16.9-д иргэд шууд буюу төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан төрийг удирдах хэрэгт оролцох эрхтэй. Төрийн байгууллагад сонгох, сонгогдох эрхтэй. Сонгох эрхийг арван найман наснаас эдэлнэ¹⁸ гэж заасан. Сонгогч эрхээ эдлэх боломжийг төрийн байгууллага хангах үүрэгтэй. Өөрөөр хэлбэл УБЕГ сонгогчийн сонгох эрхийг хангах үүднээс нэрийн жагсаалтыг үйлдэхдээ 18-аас дээш насны, шүүхээр эрх хасагдаагүй бүх иргэдэд энэ эрхийг олгох үүрэгтэй. Зөвхөн гадаад улсад оршин сууж байгаа болон хуулиар сонгох эрх нь хязгаарлагдсан иргэд л сонгогчийн бүртгэлээс хасагдах хуультай.

Тэгвэл сонгогчид сонгох эрхээ эдэлж чадаж буй эсэхийг (сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдэх ёстой хүмүүс бүгд бичигдэж чадаж буй эсэх) тодорхойлохын тулд 1992-2020 он хүртэлх УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд оролцох эрх бүхий сонгуулийн насны иргэдийн тоо болон сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тооны хооронд харьцуулалт хийлээ.

¹⁷ Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах, хүргүүлэх, өөрчлөлт оруулах харилцааг зохицуулсан заалтуудыг Хавсралт 3-аас үзнэ үү.

¹⁸ Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он. <https://www.legalinfo.mn/law/details/367>

Хүснэгт 2. Сонгуулийн насны иргэд ба сонгогчдын нэрийн жагсаалт¹⁹

Сонгуулийн жил	Сонгуулийн насны иргэдийн тоо	Сонгуулийн насны иргэдийн тоон өөрчлөлт	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоо	
				Тоо	Хувь
1992 он	1,202,704		1,085,129	117,575	9.78
1993 он	1,159,173	-43,531	1,106,403	52,770	4.55
1996 он	1,218,549	+59,376	1,147,260	71,289	5.85
1997 он	1,241,819	+23,270	1,155,228	86,591	6.97
2000 он	1,364,862	+123,043	1,247,033	117,829	8.63
2001 он	1,398,219	+33,357	1,205,885	192,334	13.76
2004 он	1,472,372	+74,153	1,279,516	192,856	13.1
2005 он	1,578,967	+106,595	1,241,268	337,699	21.39
2008 он	1,607,825	+28,858	1,542,617	65,208	4.06
2009 он	1,642,567	+34,742	1,493,217	149,350	9.09
2012 он	1,882,035	+239,468	1,840,824	41,211	2.19
2013 он	1,998,586	+116,551	1,864,273	134,313	6.72
2016 он	1,998,823	+237	1,911,047	87,776	4.39
2017 он	2,032,022	+33,199	1,990,797	41,225	2.03
2020 он			2,003,969 ²⁰		

Хүснэгтээс харахад нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоо, хувь хэмжээ сонгуулийн насны иргэдийн тоотой уялдсан чиг хандлагыг харуулахгүйгээр жил бүр хэлбэлзэн, өөрчлөгдөж ирсэн байна. Хамгийн сонин нь 1993 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үе дэх сонгуулийн насны иргэдийн тоо нь нэг жилийн өмнө (1992 онд) болсон УИХ-ын сонгуулийн үеийнхээс буурсан байна. Мөн 2016 оны УИХ-ын сонгуульд оролцох сонгуулийн насны иргэдийн тоо гурван жилийн өмнөх Ерөнхийлөгчийн сонгуулийн үед амьдарч байсан иргэдээс 237-оор нэмэгджээ. Гэтэл ҮСХ-ны “Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага” тайланд Монгол Улсын хүн амын жилийн дундаж өсөлтийн хувь 2000 онд 1.4 хувь, 2007–2009 онуудад аажим өсөж 1.9 хувь, 2010 онд эргэн саарч 1.6 хувь байснаа, 2011–2014 оны хооронд тогтвортой өссөөр 2.2 хувьд хүрчээ. Харин 2015 оноос аажмаар буурч, 2017 оны урьдчилсан гүйцэтгэлээр 1.9 хувь болж²¹ байжээ. Тэгвэл 18-аас дээш насны сонгогчдын тоо дөрвөн жилийн дунджаар 5-6 хувь өсөх ёстой.

Мөн сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчдын тоо 2005 он хүртэл нэмэгдэж байгаад, аажмаар буурч байна. Ялангуяа иргэний бүртгэлийг биеийн давцахгүй өгөгдөл (хурууны хээ) ашиглан цахимжуулснаас хойш энэ төрлийн зөрчил буурч байна.


Түүнчлэн УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчдын тоонд зөрүү гардаг, Ерөнхийлөгчийн сонгуульд сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчдын зөрүү УИХ-ын сонгуулиас их байдаг зэрэг асуудлууд гарч байна.

¹⁹ Монгол Улсын их хурлын сонгуулийн дүн (1992–2016 он), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993–2017), Сонгуулийн ерөнхий хороо. УБ, 2017 он. <https://www.gec.gov.mn/>

²⁰ Сонгуулийн ерөнхий хорооны мэдээ. 2020 оны 6 сарын 25-ны өдөр <https://www.gec.gov.mn/blog/2862>

²¹ Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага. Үндэсний статистикийн хороо. УБ., 2017 он. https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Dundaj_naslalt_and_ND.pdf&ln=Mn

Зураг 2. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоон зөрүү, хувиар²²




Сонгуулийн насны иргэдийн тоо, түүний өөрчлөлт СНЖ-д бичигдсэн сонгогчдын тооны өөрчлөлттэй уялдахгүй, зөрүүтэй байгаа нь сонгогчид сонгох эрхийн суурь болох сонгогчдын нэрийн жагсаалтад бичигдэх эрхээ эдэлж чадахгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Сонгогчийн бүртгэл үйлдэх / сонгогчдын нэрийн жагсаалт гаргах ажиллагаа хэрхэн явагддаг вэ? Ил тод байж чадаж байна уу?

Монгол Улс иргэний шилжилт хөдөлгөөнийг сонгогчийн бүртгэл үйлдэхтэй холбогдуулан санал хураах өдрөөс тодорхой хугацааны өмнө хааж, санал хураалт дууссанаар нээдэг. Одоо мөрдөж байгаа хуулиар УИХ-ын сонгуульд санал хураах өдрөөс 4 сарын өмнө²³, Орон нутгийн болон Ерөнхийлөгчийн сонгуульд санал хураах өдрөөс 2 сарын өмнө^{24,25} тус тус зогсоож байна. **Иргэний шилжилт хөдөлгөөн зогссон энэ хугацаанд сонгогчдын бүртгэлийг хийж, нэрийн жагсаалт үйлдэж, шинэчилж сонгуулиа зохион байгуулдаг.**

УБЕГ сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхдээ СЕХ болон аймаг, орон нутгийн удирдлага зэрэг төрийн бусад байгууллагуудтай хамтран ажиллах үүрэгтэй. Доорх зурагт сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэхэд оролцогч байгууллагуудын уялдаа холбоог харуулав.

Зураг 3. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд оролцогч байгууллагууд



²² Монгол Улсын их хурлын сонгуулийн дүн (1992-2016 он), Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2017), Сонгуулийн ерөнхий хороо. УБ, 2017 он. <https://www.gec.gov.mn/>

²³ МУИХСТХ-ийн 25.1. Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг ээлжит сонгуулийн жилийн 02 дугаар сарын 15-ны өдрөөс, ээлжит бус, нөхөн, дахин сонгууль явуулах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан бол уг шийдвэрийг улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад ирүүлсэн өдрийн дараах ажлын өдрөөс эхлэн зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээн. <https://www.legalinfo.mn/law/details/14869>

²⁴ АНСДИТСТХ-ийн 24.1. Иргэний засаг захиргааны нэг нэгжээс нөгөө нэгжид шилжин суурьших хөдөлгөөнийг санал авах өдрөөс 60 хоногийн өмнө зогсоож, санал авах өдрийн дараах өдрөөс сэргээн.

²⁵ МУЕСТХ-ийн 25.1. 2020 он.

УБЕГ сонгогчдын нэрийн жагсаалтыг шинэчлэхдээ СЕХ-оор дамжуулж иргэний холбогдох мэдээллийг хуульд заасан хугацаанд төрийн холбогдох байгууллагуудаас авдаг. Үүнд:

- Улсын Дээд шүүх (УДШ) эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон сонгуулийн насны иргэдийн мэдээллийг,
- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар (ШШГЕГ) хорих ял эдэлж байгаа болон эрүүгийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан, захиргааны журмаар албадан эмчлүүлж байгаа болон зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг,
- Хил Хамгаалах ерөнхий газар (ХХЕГ) 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээллийг, мөн тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр харьяа тусгай анги, салбарт нь алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг;
- Батлах хамгаалах яам (БХЯ) тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч санал авах өдөр зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг,
- Цагдаагийн ерөнхий газар (ЦЕГ) тухайн сум, дүүргийн нутаг дэвсгэрт байнга оршин суух газрын хаягийн бүртгэлгүй боловч тухайн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтны мэдээллийг, мөн зөрчлийн хэрэгт холбогдуулан баривчлагдсан сонгуулийн насны иргэдийн мэдээллийг,
- Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ) тухайн жилд Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээллийг тус тус хариуцаж гаргана.

УБЕГ сонгогчдын нэрийн жагсаалтыг дээрх төрийн байгууллагуудтай хамтран гаргаж, түүнийг нягтлан шалгах, давхардлыг арилгах, сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгуулийн эрх бүхий иргэнийг бүртгэх, эдгээртэй холбоотой гомдлыг шийдвэрлэх ажлыг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах үүрэгтэй.

Гэвч өнгөрсөн хугацаанд **дээрх төрийн байгууллагуудын шийдвэрээр хэдэн иргэн сонгуулийн эрхээ хязгаарлуулсан талаарх мэдээлэл ил тод биш** байна. Үүнд: эрх зүйн чадамжгүй нь шүүхийн шийдвэрээр тогтоогдсон, хорих ял эдэлж байгаа, 60 түүнээс дээш хоногийн хугацаагаар гадаад улсад зорчсон иргэдийн мэдээлэл тодорхойгүй байна. Мөн сонгогчийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой санал авах өдөр харьяа цэргийн алба хаагч болон ажилтан, зэвсэгт хүчний цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтан, цагдаагийн алба хаагч, дотоодын цэргийн анги, нэгтгэлд алба хааж байгаа алба хаагч болон ажилтан, Монгол Улсын харьяат болсон, иргэний харьяаллаа сэргээн тогтоолгосон, харьяатаас гарсан иргэдийн мэдээлэл тус тус нас, хүйс, аль тойрогт бүртгэлтэй сонгогч болох нь тодорхойгүй байна.

Энэ тухай ЕАБХАБ-аас 2019 онд Монгол Улсад сануулж²⁶, Монгол Улс сонгуулийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд сонгогчдын бүртгэл, нэрийн жагсаалтад анхаарахыг зөвлөснийг дурдах нь зүйтэй. Мөн гадаад улсад оршин суугаа сонгогчдын сонгох эрхээ эдлэх боломж хэрхэн хязгаарлагдаж буйг ч энд дурдах хэрэгтэй. 1990 оноос хойш гадаадад сурч, ажиллаж буй иргэдийн тоо тодорхойгүй, 2016 онд ойролцоогоор 100000²⁷-130000²⁸ гаруй иргэн гадаадад ажиллаж, амьдарч байгаа бөгөөд тэдний сонгуулийн эрх зөрчигдсөөр байгаа.

Монгол Улс 2012 онд УИХ-ын сонгуульд, 2013 болон 2017 онд Ерөнхийлөгчийн сонгуульд, гадаад улсад оршин

²⁶Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал болон Орон нутгийн сонгуулийн хуулийн төсөлд өгөх АИХЭГ-ын санал, Варшав хот. 2019. <https://www.osce.org/mn/odihr/elections/mongolia/441041>

²⁷Гадаадад ажиллаж, амьдарч, суралцаж буй Монгол иргэдийн нэгдсэн өргөдөл. <https://www.trends.mn/n/6713>

²⁸Дэлхийн аль улсад Монголчууд олноор амьдарч байна вэ? <https://ikon.mn/n/u9h>

суугаа иргэдэд сонгуульд оролцох эрхийг олгож байсан буюу тэд нийт гурван удаа л сонгуульд оролцож саналаа өгч байсан. Хуулиар гадаад улсад оршин суугаа иргэд санал өгөх хүсэлтээ гаргасан байх бөгөөд Монгол Улсын дипломат төлөөлөгчийн газар саналаа өгөх боломжтойгоор зохион байгуулж байна.

Хүснэгт 3. Гадаад улсад оршин сууж байхдаа саналаа өгсөн сонгогчдын тоо

Сонгууль	Санал авах өдөр	Дипломат төлөөлөгчийн газрын тоо	Саналаа өгөхөөр бүртгүүлсэн сонгогчийн тоо	Саналаа өгсөн сонгогчийн тоо
2012 оны УИХ-ын сонгууль	6-р сарын 10-ны өдөр	39	4276	2779 ²⁹
2013 оны Ерөнхийлөгчийн сонгууль	6-р сарын 14-16-ны өдрүүд	39	6494	4242
2017 оны Ерөнхийлөгчийн сонгууль	7-р сарын 4-5-ны өдрүүд	42	7209	4767

2012 оны УИХ-ын сонгуулийг эс тооцвол (тогтолцооноос хамаарч гадаад улсад оршин суугаа сонгогчдын санал өгөх эрх нээгдсэн) гадаад улсад оршин суугаа иргэд зөвхөн Ерөнхийлөгчийн сонгуульд л оролцож сонгох эрхээ эдэлсэн байна.

Гадаадад 6 сараас дээш хугацаагаар албан болон хувийн ажлаар ажиллаж, амьдарч байгаа сонгогчдын бүртгэл (нас, хүйс, байршлын талаарх) мэдээлэл тодорхой бус, ил тод биш байгаа нь тэдний саналаа өгөх эрхийг зөрчиж буй нэг хэлбэр болж байна.

УБЕГ-аас сонгуулийн насны иргэдийн тоо болон сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй сонгогчдын тоог ил тод болгохгүй, зөвхөн сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн тоог зарладаг. (ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн санд байгаа сонгогчдын оролцооны мэдээллээс харна уу). Өөрөөр хэлбэл сонгуулийн өмнө яг хэдэн сонгогч сонгуулийн эрхтэй байгаа, сонгогчдын нас, хүйс, байршлаар нь тодорхой зарладаггүй нь сонгогчдын бүртгэлийн үнэн бодит байдалд эргэлзэх эргэлзээг төрүүлж байна. (Тухайлбал, 2020 оны УИХ-ын сонгуулийн үеэр 18-аас дээш насны эрх бүхий хэдэн иргэн байсан тоо олон нийтэд зарлагдаагүй. Зөвхөн сонгогчдын нэрийн жагсаалтад хэдэн иргэн бүртгэгдсэн тухай мэдээг СЕХ зарласан)

Хүснэгт 4. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, саналаа өгсөн сонгогчдын тоо (мянган хүн)³⁰

Сонгуулийн жил	Улсын Их Хурлын сонгууль		Орон нутгийн хурлын сонгууль	
	Нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо	Сонгуульд санал өгсөн сонгогчийн тоо	Нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо	Сонгуульд санал өгсөн сонгогчийн тоо
1992 он	1,085.20	1,037.40	Мэдээлэл байхгүй	
1996 он	1,147.30	1,057.20	1,061.80	765.4
2000 он	1,247.00	1,028.00	1,105.40	728.8
2004 он	1,329.80	1,088.30	1,089.30	732.2
2008 он	1,542.60	1,179.50	1,265.50	830.6
2012 он	1,840.80	1,238.50	1,852.20	979.8
2016 он	1,911.00	1,420.80	1,921.10	1,161.10
2020 он	2021 оны 1-р сарын 20-ны байдлаар мэдээлэл ороогүй.			

²⁹ Монгол Улсын Их хурлын сонгуулийн дүн. (1992-2016 он) Сонгуулийн ерөнхий хороо. УБ., 2017. <https://gec.gov.mn/>

³⁰ Сонгогчдын оролцоо. ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сан. 2021 он.

Сонгогчдын бүртгэл / нэрийн жагсаалтыг хэн, ямар байдлаар авах боломжтой вэ?

2012 оны УИХ-ын ээлжит сонгуулиас өмнө УБЕГ сонгогчдын нэрийн жагсаалтыг цаасан хэлбэрээр гаргаж, сонгуулийн хэсгийн хороодод хуульд заасан хугацаанд хүргүүлж, сонгогчдод “Сонгогчийн үнэмлэх” олгодог байсан. Сонгогчийн үнэмлэх нь тухайн сонгогчийг хэддүгээр тойргийн сонгогч болох, аль хэсэгт бүртгэлтэй байгааг илтгэдэг байв. Сонгогч санал авах өдөр иргэний үнэмлэхийн хамт сонгогчийн үнэмлэхтэй ирж санал өгөх хуулийн зохицуулалттай байсан.

Харин 2012 оны УИХ-ын сонгуулиас эхлэн сонгогчдын бүртгэлийг биеийн давхцахгүй өгөгдөл (гарын хурууны хээ) ашиглаж явуулж эхэлсэн. Мөн сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим, цаас гэсэн хоёр хэлбэрээр бэлтгэж иргэдэд танилцуулдаг болсон. Сонгогчдын нэрийн урьдчилсан жагсаалтыг сонгогчдын цахим бүртгэлд үндэслэн хэвлэж хуульд заасан хугацааны дагуу сонгуулийн хэсгийн хороодод хүргүүлдэг³¹.

Сонгогч нь:

1. УБЕГ-ын цахим хуудсанд өөрийн регистрийн дугаарыг оруулан өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах (эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас хүйс, регистрийн дугаар, байнга оршин суугаа хаяг)³² эрхтэй.
2. Хэсгийн хорооны байранд өөрийн биеэр очиж цаасан суурьтай сонгогчдын нэрийн жагсаалтаас өөрийн болон гэр бүлийн гишүүдийн мэдээлэлтэй танилцах³³ эрхтэй.

Сонгогчид сонгуулийн хэсгийн хороонд сонгогчдын нэрийн жагсаалтад байгаа **өөрсдийн мэдээлэлтэй танилцах** албан ёсны хугацааны үед өөрсдийн **бүртгэлээ шалгах**аас гадна **бүртгүүлэх хүсэлтээ гаргах, мэдээллээ засах эсвэл санал авах өөр сонгуулийн хэсгийн хороо руу шилжих тухай хүсэлтээ өөрийн байнга оршин суугаа газрынхаа хэсгийн хороонд гаргах боломжтой**. УБЕГ-аас сонгогчдыг мэдээллээ шалгахыг уриалсан сонгогчдын боловсролд зориулсан мэдээллийг хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгмийн мэдээллийн сүлжээгээр хүргэдэг.

Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвслийн тухайд:

- Сонгуульд оролцохоор бүртгүүлсэн нам, эвсэл нь сонгогчдын нэрийн жагсаалтын холбогдох хэсгийг санал авах өдрөөс (МУИХСтХ-д 20-иос доошгүй хоногийн өмнө, МУЕСТХ-д 2-оос доошгүй хоногийн өмнө) цахим хэлбэрээр (PDF) нэг удаа авах боломжтой³⁴ (сонгогчдын эцэг /эх/-ийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг хамаарна). Тус жагсаалтыг олшруулахыг хуулиар хориглосон байдаг. Харин сонгогчдын нэрийн жагсаалтыг авах эрх нь **Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн сонгуулийн тухай хуульд тусгагдаагүй (хасагдсан) байна**. Энэ нь хуулийн зохицуулалтууд ялгаатай байгааг харуулж байна.
- Бусад оролцогч талууд болох бие даан нэр дэвшигч, сонгуулийг ажиглах гадаад болон дотоодын ТББ, иргэний нийгмийн байгууллага, судлаач, олон нийтэд тус мэдээлэл нь хаалттай байдаг.

³¹ МУИХСтХ-ийн 20.10 дахь заалт. Хэсгийн хороо сонгогчдын нэрийн жагсаалтыг хүлээн авсан өдрөөс эхлэн өөрийн ажиллах байранд, өөрийн ажиллах байргүй бол сум, хорооны Засаг даргын Тамгын газрын байранд сонгогч өөрт нь холбогдох мэдээлэлтэй чөлөөтэй танилцах боломж олгоно.

³² МУИХСтХ-ийн 20.4 дүгээр заалт. МУЕСТХ-ийн 9.2.2, 19.4 дүгээр заалт

³³ МУИХСтХ-ийн 20.10 дахь заалт. МУЕСТХ-ийн 19.10 дүгээр заалт

³⁴ МУИХСтХ-ийн 20.13 дугаар заалт, МУЕСТХ-ийн 19.15 дугаар заалт

2.3 СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААЛТЫН ҮЕ

Үр дүнгийн хураангуй

Сонгуулийн ирцийн мэдээг гаргах, нэгтгэх, зарлах үйл ажиллагааг зохицуулсан эрх зүйн зохицуулалтыг САЙЖРУУЛАХ, ТОДОРХОЙ БОЛГОХ шаардлагатай.

- Сонгуулийн санал хураалт болох өдөр болдог үйл ажиллагааг энд хамруулах бөгөөд энэ өдөр сонгогчдын бүртгэл/нэрийн жагсаалтыг нягтлах, бүртгэх, ирцийг мэдээлэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.
- УБЕГ-ын итгэмжлэгдсэн ажилтан сонгогчийг санал хураах байранд ирэх үед бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийг хариуцан ажилладаг.
- СЕХ-ны тогтоолоор сонгогчдын ирцийн мэдээг 12:00, 17:00, 22:00 цагуудад хүлээн авах ба 12:00, 17:00 цагийн ирцийн мэдээнд нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, саналаа өгсөн сонгогчдын тоо, хувь байх, 22:00 цагийн байдлаар нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, санал өгсөн сонгогчдын тоо, хувь, хүйс, 18-25, 26-40, 41-55, 56 дээш гэсэн насны ангиллаар мэдээ өгөхийг тус тус заажээ.
- Ирцийн мэдээг дээрх маягтын дагуу гаргаж харьяалагдах дээд шатны хороодод утсаар, цахим шуудангаар мэдээлдэг.

Сонгуулийн ирцийн мэдээг гаргах, нэгтгэх, зарлах үйл ажиллагааг зохион байгуулдаг байгууллагуудын уялдаа холбоог САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.

- Сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ болон СЕХ нь өөр өөрийн нэгжээр дамжуулан нэгтгэж авдаг. Энэ нь УБЕГ, СЕХ-ны тус тусын журмаар зохицуулагддаг.
- 2020 оноос өмнөх сонгуулиудад ирцийг СЕХ-ноос зарлаж байсан бол 2020 онд УБЕГ зарласан. Аль байгууллага нь мэдээг албан ёсоор нэгтгэх, зарлах тухай, мөн хоёр байгууллагын мэдээнд зөрүү гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх тухай эрх зүйн зохицуулалт байдаггүй.

Ирцийг мэдээлж буй хэлбэр нь хүртээмжтэй бус, нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангахгүй байгаа тул САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ.

- СЕХ (УБЕГ) санал хураалтын өдөр хэсгийн хороодоос ирцийн мэдээг 12:00, 17:00, 22:00 цагуудад хорооны баталсан маягтын дагуу нэгтгэн авч аймаг, дүүрэг (тойрог) тус бүрийн ирцийн хувийг уншиж зарладаг. Энэ нь хүртээмжгүй, нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангадаггүй.
- Олон нийт ирцийн мэдээлэлтэй хязгаарлагдмал байдлаар танилцах боломжтой байдаг.
- Ирцийн мэдээллийг ил тод хүргэхийн тулд Лийд төгсөгчдийн холбооноос IKON.mn, СЕХ-той хамтран УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн ирцийг газар зүйн мэдээллийн систем ашиглан, насны ангиллаар ялган харуулсан нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангасан мэдээлэл түгээх эхний алхам болсон.

Дэлгэрэнгүй дүн

Сонгогчдын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагаа, ирцийг нэгтгэх, мэдээлэх үйл ажиллагааг хэн хариуцдаг вэ?

МУИХСтХ-н 22.5-д³⁵ “Итгэмжлэгдсэн ажилтан энэ хуульд заасны дагуу сонгогчдын нэрийн жагсаалтын цаасан болон цахим хувилбартай танилцах, өөрчлөлт оруулах, сонгогчдын бүртгэлийг тулган шалгах, санал авах өдөр сонгогчдыг бүртгэх, таньж оруулах, техник хэрэгсэл, программ хангамжийг хариуцан ажиллана.” хэмээн заасан байдаг. Мөн УБЕГ-ын даргын А/372³⁶, А/961³⁷ тоот тушаалаар дээрх үйл ажиллагааг хэрхэн явуулахыг нарийвчлан журамласан. **УБЕГ-ын итгэмжлэгдсэн ажилтан дээр дурдсан сонгогчдын бүртгэлтэй холбоотой үйл ажиллагааг хариуцан явуулдаг** байна.

Харин ирцийн мэдээг 1) УБЕГ-ын итгэмжлэгдсэн ажилтнаас УБЕГ-т, мөн 2) Сонгуулийн хэсгийн хорооноос СЕХ-д мэдээлдэг байна. Өөрөөр хэлбэл **УБЕГ болон СЕХ нь өөр өөрийн нэгжээр дамжуулан ирцийн мэдээг нэгтгэж авдаг.**

УБЕГ-ын итгэмжлэгдсэн ажилтан нь УБЕГ-ын даргын А/372, А/961 тоот тушаал бүхий нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмуудад зааснаар “Итгэмжлэгдсэн ажилтан сонгуулийн санал авах өдөр, сонгогчдын бүртгэлийн нээлтийн, явцын, хаалтын тайланг төрийн захиргааны байгууллагаас тогтоосон хугацаанд хэвлэн, Улсын бүртгэлийн хэлтэст, Улсын бүртгэлийн хэлтэс иргэний бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид мэдээлнэ” гэснийг баримталж ирцийн мэдээллийг дээд шатны байгууллагадаа мэдээлдэг.

Ирцийн мэдээллийг хэсгийн хороодоос сум, дүүргийн сонгуулийн хороо руу утсаар мэдээлдэг. Сум, дүүргийн сонгуулийн хороо мэдээллийг нэгтгээд аймаг, нийслэлийн хороод руу утсаар болон интернетээр явуулах бөгөөд аймаг, дүүрэг нэгтгэсэн дүнгээ СЕХ-д интернетээр хүргүүлдэг. Ирцийн мэдээг хэсгийн хороод бүртгэлийн машинаас тогтсон цагт хэвлэн авч, тухайн билл дээрх мэдээллийг шат шатны харьяалагдах хороодод явуулдаг.

Харин СЕХ-ны 2020 оны 4 сарын 27-ны өдрийн 46 тоот тогтоол³⁸-ыг дагаж гарсан маягт 1, 2-р хавсралтаар сонгогчдын ирцийн мэдээллийг цуглуулж, мэдээлэл өгөх харилцааг зохицуулсан.


³⁵(АНСДИТХст-ын 22.5, МУЕСтХ-н 22.5)

³⁶ Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам /УБЕГ-ын даргын А/372 дугаар тушаал/ /2020.03.24/ <https://burtgel.gov.mn/post/43795>

³⁷ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам /УБЕГ А961/ <https://burtgel.gov.mn/post/43958>

³⁸ СЕХ-ны 46 дугаар тогтоол. <https://gac.gov.mn/>

Зураг 5. Маягт 2. (.... сонгуулийн ... дугаар тойргийн санал хураалтын дүнгийн нэгтгэл)



Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны
2020 оны 5-р дугаар сарын 24-ны өдрийн
7/О. дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

..... СОНГУУЛИЙН ДУГААР ТОЙРГИЙН САНАЛ ХУРААЛТЫН
ДҮНГИЙН НЭГТГЭЛ

..... аймаг, нийслэл, сум, дүүрэг оны дугаар сарын-ны өдөр

№	Хэсгийн дугаар	Нарийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн		Үүнээс										
		-ийн төлөө өгсөн саналын	-ийн төлөө өгсөн саналын	-ийн төлөө өгсөн саналын	-ийн төлөө өгсөн саналын		санал огт тэмдэглээгүй саналын хуудасны				
			тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	тоо	хувь	
	А	Б	В	Г	Д	Е	Ж	З	И	К	Л	М	Н	О	
1-р хэсэг														
2-р хэсэг														
3-р хэсэг														
	... сум /дүүрэг/-ын дүн														
4-р хэсэг														
5-р хэсэг														
	... сум /дүүрэг/-ын дүн														
	ТОЙРГИЙН ДҮН														

.....-ИЙН СОНГУУЛИЙН ХОРООНЫ ДАРГА /...../

тэмдэг: НАРИЙН БИЧГИЙН ДАРГА /...../

Тайлбар: Сум, дүүргийн сонгуулийн хороо нь өөрийн харьяа хэсгийн хороодоос ирүүлсэн санал тоолох төхөөрөмжөөс гарсан санал хураалтын дүнгийн хуудас дахь мэдээллийг үндэслэн дүнг нэгтгэн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг, нийслэлийн сонгуулийн хороо сонгуулийн тойргийн хэмжээнд нэгтгэсэн дүнг Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлнэ.

Энэ бол сонгуулийн ирцийн сүүлийн дүнг нэгтгэх, СЕХ-д хүргүүлэх зааварчилгаа бөгөөд нийт жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо, саналаа өгсөн сонгогчийн тоо, хувь, үүнээс нэр дэвшигч тус бүрээр авсан саналын тоо, хувь, санал огт тэмдэглээгүй саналын хуудасны тоо, хувийг өгөхөөр заасан.

Ийнхүү сонгуулийн санал авах өдрийн ирцийн мэдээллийг УБЕГ нь өөрийн итгэмжлэгдсэн ажилтнаас, СЕХ нь сонгуулийн хорооны хэсгийн ахлагчаас тус тус авах бөгөөд **эдгээр 2 эх сурвалжийн мэдээллийг ямар шалгуураар, аль байгууллагын мэдээллийг олон нийтэд зарлах тухай, эсхүл эдгээр мэдээллүүдийг нэгтгэх байдлаар мэдээлэх зэргээр нарийвчилсан хуулийн болон журмын зохицуулалт байхгүй.**

2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ олон нийтэд зарласан бол өмнөх жилүүдэд сонгууль зохион байгуулах төв байгууллагын хувьд СЕХ зарлаж ирсэн. Аль байгууллага үүнийг хариуцах вэ гэдэг дээр эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

Ирцийг хэрхэн мэдээлдэг вэ? Ил тод, хүртээмжтэй байж чаддаг уу?

2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ-с 13:00 болон 17:00 цагуудад зарласан. Харин 22:00 цагийн хаалтын нэгтгэсэн мэдээг сонгуулийн санал хураалт дууссанаас 1 өдрийн дараа ikon.mn УБЕГ-аас авч сайтдаа байрлуулсан. (Гэхдээ санал хураалт дуусах үед нийт сонгогчдын ирц улсын дунджаар хэдэн хувьтай байсныг танилцуулсан)

Харин Аймаг, нийслэл, сум, дүүргийн сонгуулийн санал хураалтын ирцийн мэдээг санал хураалтын өдөр 13:00, 17:00, 22:00 цагуудад сонгуулийн хэсгээс сум, аймаг, дүүрэгт нэгтгэн Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлсэн. Сонгуулийн ерөнхий хороо санал хураалтын ирцийн мэдээллийг олон нийтэд аймаг, дүүрэг тус бүрээр хувиар зарлан танилцуулсан.

СЕХ, УБЕГ санал хураалтын өдөр хэсгийн хороодоос ирцийн мэдээг 12:00, 17:00, 22:00 цагуудад хорооны баталсан маягтын дагуу нэгтгэн авч аймаг, дүүрэг (тойрог) тус бүрийн ирцийн хувийг **уншиж зарладаг**. Ингэхдээ тойрог тус бүрийн нийт сонгогчийн тооноос санал өгсөн сонгогчийн тоогоор хувилж зарладаг. Жишээлбэл, 12:00 цагийн байдлаар “Архангай аймагт ирц 25%-тай, Баянхонгор аймагт ...% ийн ирцтэй байна” (энд дурдаж буй жишээ тоо нь зохиомол гэдгийг анхаарна уу) гэх зэргээр олон нийтэд мэдээлдэг. СЕХ-ны тогтоол дээр хэсгийн хороодоос ирэх ирцийн мэдээ нь 12:00 болон 17:00 цагийн байдлаар нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, саналаа өгсөн сонгогчдын тоо, хувь зэрэг мэдээлэл байх, 22:00 цагийн тухайд нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, санал өгсөн сонгогчдын тоо, хувь, хүйс, 18-25, 26-40, 41-55, 56-с дээш гэсэн насны ангиллаар мэдээ өгөхийг тус тус заасан ч олон нийтэд зарлахдаа зөвхөн дээрхийг уншаад өнгөрдөг.

Гэвч ирцийг мэдээлж буй дээрх байдал нь ил тод, хүртээмжтэй байж чадахгүй байгаа нь эргэлзээ, хардлагыг дагуулах үндэс болдог. Тухайлбал, ирцийн мэдээ нь

- Тухайн тойрогт сонгуулийн насны хэчнээн хүн байна,
- Тэдний хэд нь сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн байна,
- Хэдэн сонгогч шилжин очсон, эсвэл шилжин явсан,
- Шилжин очсон сонгогчдын тоо нь тухай тойрог, хэсгийн дүнд нөлөөлөхөөр байгаа эсэх,
- Нэг сонгогч яг нэг хэсэгт бүртгэлтэй байгаа эсэх, тэдний нас, хүйсийн ангилал
- Тухайн тойрогт сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 18-25 насны (ангилал тус бүрээр) хэдэн сонгогч байна,
- Тэдний хэдэн хувь нь саналаа өгсөн байна,
- Хүйсийн хувьд ямар ялгаатай байна гэх мэт харьцуулсан мэдээллийг агуулдаггүй.

Сонгуульд оролцогч бүх талууд ижил ойлголттой, сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн ирцийн мэдээлэл нь нээлттэй өгөгдлийн форматаар олон нийтэд хүртээмжтэй түгдэг байснаар ардчилсан сонгуулийн “нэг сонгогч - нэг санал” зарчим хэрэгжиж байгаа эсэхэд олон нийт итгэх боломж бүрдэнэ. Мэдээллийн хүртээмж, үнэн зөв ойлголтгүйгээс үүдэн сонгуульд үл итгэх, сонгуулийн оролцоо багасах зэрэг сөрөг талууд бий болдог.

Ирцийн мэдээллийг ил тод хүргэх дээрх үзэл баримтлалын хүрээнд Лийд төгсөгчдийн холбооноос IKON.mn, СЕХ-той хамтран УИХ-ын 2020 оны ээлжит сонгуулийн ирцийг газар зүйн мэдээллийн систем³⁹ ашиглан, насны ангиллаар ялган харуулах санаачилгыг дэвшүүлж, ажил хэрэг болгосон.


Ийнхүү ил тод болгон харуулсан мэдээлэл нь тойрог бүр дэх

- Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо
- Түр хасав төлөвөөс сэргээсэн сонгогчийн тоо
- Сонгогчийн тоо (Түр хасав төлөвөөс сэргээж, сонгогчдын нэрийн жагсаалтад оруулсан)
- Санал өгсөн сонгогчийн тоо
- Санал өгсөн сонгогчийн хувь
- Насны ангиллаар (Нийт санал өгсөн сонгогчдыг насны ангиллаар)


³⁹ <https://ikon.mn/elections/2020/irts/t>

- Насны ангиллаар (Насны бүлэг бүрд санал өгөх ёстой сонгогчдын хэчнээн нь өгсөн байгааг тоо, хувиар зэргийг харуулсан.

Зураг 6. 2020 оны УИХ-ын сонгуулийн ирц⁴⁰ (Улсын хэмжээнд)



Зураг 7. 2020 оны УИХ-ын сонгуулийн ирц⁴¹ (Хөвсгөл аймгийн хэмжээнд)



⁴⁰ <https://ikon.mn/elections/2020/irts/t>

⁴¹ <https://ikon.mn/elections/2020/irts/t>

Зураг 8. УИХ-ын 2020 оны сонгуулийн ирц⁴² (Аймаг, тойргоор)

Ирц дээр насны ангилал тус бүрээр

18-25 26-40 41-55 56 дээш

Хүснэгтээр

Тойрог	Аймаг/ дүүрэг	Хэсгийн тоо	Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн	Түр хасав төсөвөөс сэргээсэн	Нийт сонгогчдын тоо	Санал өгсөн сонгогчдийн тоо (22 цаг)	Санал өгсөн сонгогчдийн хувь (22 цаг)	18-25	26-40	41-55	56 дээш	Санал өгсөн сонгогчийн тоо 22 цагийн байдлаар
1-р тойрог	АРХАНГАЙ	105	61.194	33	61.227	45.469	74.3%	7.106 (55.2%)	14.944 (72.6%)	14.369 (88.5%)	9.050 (78.7%)	45.469
2-р тойрог	БАЯН-ӨЛГИЙ	96	59.386	208	59.594	49.993	83.9%	9845 (73.9%)	18640 (83.0%)	113.711 (96.3%)	7.797 (83.3%)	49.993
3-р тойрог	БАЯНХОНГОР	105	56.574	36	56.610	45.318	80.1%	8200 (69.4%)	16.295 (78.2%)	12.962 (90.6%)	7.861 (81.6)	45.318

Эдгээр нь нээлттэй өгөгдлийн бүрэн бүтэн байдал гэдэг шалгуурыг хангасан. Учир нь УБЕГ болоод СЕХ-ноос сонгуулийн дараа насны ангилалтайгаар гаргасан сонгуулийн ирцийн мэдээлэлд тухайн насны ангилалд нийт хэдэн сонгогч байгаад хэд нь санал өгсөн мэдээлэл байдаггүй. Зөвхөн хувиар илэрхийлдэг нь өгөгдлийг цааш дахин боловсруулах боломжгүй болгодог. Нээлттэй өгөгдлийн хамгийн чухал зорилго бол төрийн мэдээллийг нээлттэй болгож өгөгдлийг боловсруулж олон төрлийн зорилгоор ашиглах боломжийг бүрдүүлдэгт оршино.

⁴² <https://ikon.mn/elections/2020/irts/t>

2.4 СОНГУУЛИЙН САНАЛ ХУРААЛТ ДУУССАНЫ ДАРААХ ҮЕ

Үр дүнгийн хураангуй

Сонгуулийн дүнг зарлах үед сонгогчийн оролцоо, ирцийг зарладаг боловч аль байгууллага хариуцах тухай ЗОХИЦУУЛАЛТ БАЙХГҮЙ. (САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ)

- Сонгуулийн санал хураалт дууссан 22:00 цагаас хойших (АНСДИТХС үед 20:00 цаг) үйл ажиллагааг энд хамруулах бөгөөд энэ үед ирцийг баталгаажуулах, мэдээлэх зэрэг үйл ажиллагаа явагддаг.
- Сонгуулийн дүнг нэгтгэх, баталгаажуулахтай хамт сонгуулийн ирцийн хаалтын мэдээг мөн баталгаажуулдаг.

СЕХ-ны цахим сайтад сонгуулийн ирцийн мэдээ ИЛ ТОД БАЙРШСАН боловч маш ерөнхий, бүрэн бус, нээлттэй өгөгдлийг дэмждэггүй хэлбэртэй байна. (САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ)

- СЕХ, УБЕГ, ҮСХ нь үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлийн хүрээнд сонгуулийн ирцийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх, ил тод болгох үүрэгтэй төрийн байгууллагууд юм.
- Сонгуулийн ерөнхий хорооны тухайд ирцийн мэдээллийг цаасан эмхэтгэл хэлбэрээр болон цахим хэлбэрээр (СЕХ-ны www.gec.gov.mn цахим хуудсанд байршдаг тус мэдээлэлд цаасан эмхэтгэлийн адил сонгуулиудын дүн, ирцийн хамт байршдаг. PDF хэлбэрээр татаж авах боломжтой) мэдээлдэг.
- СЕХ-ны веб сайтад 1992-2016 оны УИХ-ын, 1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн байршсан байна. Гэвч эдгээр мэдээлэл нь өгөгдлийн хувьд дахин боловсруулах боломжгүй хэлбэртэй, хэдийгээр газар зүйн байдлаар ялгасан ч нас, хүйсийн байдлаар ангилаагүй байна.
- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн зөвхөн 2016 оны ээлжит сонгуулийн дүн байршсан, үүнээс өмнөх дүнгүүд байхгүй. Мөн зөвхөн санал хураалтын дүн байх ба сонгогчдын ирцийн мэдээлэл байхгүй байна.

ҮСХ-ны сайтад байршсан ирцийн мэдээлэл нь ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ ӨГӨГДЛИЙГ ДЭМЖСЭН хэлбэртэй боловч хэт ерөнхий байна. (САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ)

- ҮСХ-ны www.1212.mn сайтаас УИХ-ын сонгуулийн 1992-2016 оны сонгогчдын ирцийн мэдээг (Орон нутгийнх 1996-2016 он) нэрийн жагсаалтад бүртгэгдсэн хүний тоо, сонгуульд санал өгсөн сонгогчдын тоо, оролцооны хувиар авах боломжтой байна.
- ҮСХ-ны мэдээллийг дахин боловсруулах боломжтой буюу Монгол Улсад мөрдөж буй нээлттэй өгөгдлийн xls, csv, txt, json форматуудаар авах боломжтой ч газар зүйн байрлал, насны бүлэг болон хүйсээр ангилан харах боломжгүй, зөвхөн улсын хэмжээний нэгдсэн тоо байна.

УБЕГ-ын сайтад ирцийн мэдээлэл байхгүй, харин өөр мэдээллийн эх сурвалж дээр байршжээ.

- УБЕГ-с гаргасан ирцийн мэдээ өөрийн сайт дээр нь байршаагүй, харин бусад байгууллагын сувгууд дээр байна. Тухайлбал 2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээ нь www.ikon.mn сайтад, орон нутгийн сонгуулийн ирцийн мэдээ нь СЕХ-ны Фэйсбүүк хуудсанд тус тус нийтлэгджээ.

Ил тод байршсан дээрх ирцийн мэдээлэлд нарийвчилсан дүн шинжилгээ хийх, статистикийн үндсэн үзүүлэлттэй харьцуулах боломж ХЯЗГААРЛАГДМАЛ байна. (САЙЖРУУЛАХ ШААРДЛАГАТАЙ)

- СЕХ, ҮСХ-ны мэдээлэлд тулгуурлан дүгнэвэл зөвхөн улсын хэмжээнд сонгууль бүрээр сонгогчдын ирц хэдэн хувьтай байж ирснийг, мөн аймгуудаар ангилж, ялгах гм хязгаарлагдмал боломжтой байна.
- Сонгогчдын ирц, оролцоог нэмэгдүүлэхийн тулд ирцийн мэдээллийг нас, хүйс, газар зүйн байршлаар илүү нарийвчлалтай ангилахаас эхлүүлээд статистикийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай байна.

Дэлгэрэнгүй дүн

Сонгогчийн ирцийг баталгаажуулах, мэдээлэх үйл ажиллагаа хэрхэн явагддаг вэ?

Сонгуулийн санал хураах үйл ажиллагаа Улаанбаатар хотын цагаар 22:00 цагт хаагдана (2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн санал хураалт 20:00 цагт). Ингэснээр сонгуулийн дүнг баталгаажуулах, хүргүүлэх, мэдээлэх үйл ажиллагааг үйлдэнэ. Сонгуулийн дүнг баталгаажуулах үйл ажиллагаа нь санал хураалт дууссаны дараа эхэлдэг бөгөөд хэсгийн хорооны дарга санал тоолох автомат машинаас гарсан тооллогын хуудсыг танилцуулж, тэмдэглэл хөтөлнө. Дараа нь санал тоолох машинд өгөгдөл дамжуулан модем холбож хэсгийн санал хураалтын дүнг СЕХ-ны серверт дамжуулдаг. СЕХ 15 хоногийн дотор сонгуулийн дүнг нэгтгэж, олон нийтэд танилцуулах үүрэгтэй.⁴³

Мөн санал авах ажиллагаа дууссаны дараа сум, дүүргийн сонгуулийн хороо харьяа бүх хэсгийн 50 хүртэл хувийг нь санамсаргүй сонголт /сугалах/-ын аргаар сонгож, хяналтын тооллого хийлгүүлэх хуультай. Энэ дагуу СЕХ сонгуулийн дүнг баталгаажуулахын тулд 2020 оны 4 сарын 14-ны өдөр 22 тоот “Хяналтын тооллого хийх журмыг батлах тухай”⁴⁴ тогтоолыг баталсан. Тойргийн хороо энэ журмыг баримталж сонгуулийн дүнг баталгаажуулах ажлыг зохион байгуулна. Сонгогдсон хэсгийн хороо хяналтын тооллого зохион байгуулсан үйл ажиллагааг баримтжуулах, протокол хөтөлж аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хүргүүлнэ. Аймаг, нийслэлийн сонгуулийн хороо СЕХ-д мэдээллийг дамжуулна. **Сонгуулийн дүнг зарлах үедээ сонгогчдын оролцоо, ирцийг хамт зарлаж, хүчинтэйд тооцох эсэхийг мэдэгддэг.**⁴⁵

⁴³ МУИХСтХ-ийн 71.5.1 дэх “хэсгийн хороо нь санал тоолох төхөөрөмжөөс гарсан дүнгийн хуудсыг ажиглагч нарт өгч, дүн танилцуулсан тухай тэмдэглэл хөтлөх”, 71.6 дахь хэсэгт “Хэсгийн хороо дүн дамжуулах, танилцуулах ажиллагааг ил тод, нээлттэй явуулна. Хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг байлцуулж болно.”, мөн зүйлийн 71.13 дахь хэсэгт “Санал авах байранд ажилласан ажиглагчийн хүсэлтийг үндэслэн саналын хуудасны зурган мэдээллийг өгөх бөгөөд уг ажлыг хэсгийн хороо, мэдээллийн технологийн даамал болон итгэмжлэгдсэн ажилтан хариуцна.”

⁴⁴ Хяналтын тооллого хийх журмыг батлах тухай СЕХ-ны 22-р тогтоол. https://gec.gov.mn/uploads/2020/tusul_juram/

⁴⁵ МУИХСтХ-ийн 73.1 дэх хэсэгт “Хэсгийн хороо санал тоолох төхөөрөмжөөс хэвлэсэн тухайн хэсгийн санал хураалтын дүнг танилцуулсны дараа санал хураалтын дүнгийн хуудсыг сонгуулийн бусад бичиг баримтын хамт сум, дүүргийн сонгуулийн хороонд, сум, дүүргийн сонгуулийн хороо нь аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд, аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь Сонгуулийн ерөнхий хороонд тус тус нэн даруй хүргүүлнэ.”



МУИХСтХ-н хуулийн 71-р зүйлийн 71.16 дахь хэсэгт “Хяналтын тооллого хийх ажиллагаанд ажиглагч, **хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг ажиглагчаар оролцуулж болно**” гэж зааснаас үзвэл хяналтын тооллогын үед ч мөн хэвлэл мэдээллийн байгууллага тухайн нөхцөл байдлыг мэдээлэх, иргэдийн сонгуулийн ирцийн мэдээллээр хангах, мөн хяналтын тооллогоор сонгуулийн санал хураалт үнэн зөв явагдсан эсэх талаарх мэдээллийг олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулах боломжтой байна.

Дээрх үйл ажиллагаа хуулийн дагуу явагдсанаар МУИХСтХ-н 20 дугаар зүйлийн 20.4, 20.5, (АНСДИТХСтХ-н 20.4, 20.5, нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журмын 3.2) тус тус заасны дагуу сонгогчийн өөрийн холбогдох сонгуулийн бүртгэлийн мэдээлэлтэй танилцах эрх дуусгавар болдог.

Ийнхүү сонгуулийн үйл ажиллагаа амжилттай зохион байгуулагдсаны дараа СЕХ нь Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6 дахь хэсэгт “**ард нийтийн санал асуулгын болон сонгуулийн хууль тогтоомжийг нийтэд тайлбарлан таниулах, сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, энэ талаар сургалт, судалгаа явуулах болон сонгуулийн явц, хугацааны талаар сонгогчдыг мэдээллээр хангах;**” бүрэн эрхийнхээ хүрээнд тухайн сонгуулийн зохион байгуулалт, үйл ажиллагаа болон бусад хэрэгцээт статистик мэдээллийг багтаасан ном, сэтгүүлийг эрхлэн гаргаж олон нийтийг сонгуулийн ирцийн мэдээллээр хангадаг.

Сонгуулийн ирцийн мэдээлэл ил тод, хүртээмжтэй байж чадаж байна уу?

СЕХ, УБЕГ, ҮСХ нь үйл ажиллагааныхаа зорилго, чиглэлийн хүрээнд сонгуулийн ирцийн мэдээллийг олон нийтэд ил тод болгох үүрэгтэй төрийн байгууллагууд юм. Нөгөө талаас иргэдийн сонгох эрхийг хамгаалах үүрэгтэй төрийн захиргааны байгууллагууд энэ үүргээ олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, хариуцлагатайгаар хэрэгжүүлж чадаж байна уу гэдэг асуулт гарч ирж байна.

Сонгуулийн ерөнхий хорооны тухайд:

Сонгуулийн санал хураалт дууссаны дараа ирцийн мэдээллийг СЕХ албан ёсоор олон нийтэд ил тод болгодог. Мэдээллийн хэлбэр нь

1. Цаасан эмхэтгэл хэлбэрээр (сонгуулиудын дүн, ирцийн хамт байх бөгөөд СЕХ дээр үнэгүй тараагддаг)
2. Цахим хэлбэрээр (СЕХ-ны www.gec.gov.mn цахим хуудсанд байршдаг тус мэдээлэлд цаасан эмхэтгэлийн адил сонгуулиудын дүн, ирцийн хамт байршдаг. PDF хэлбэрээр татаж авах боломжтой)

СЕХ-ны цахим хуудсанд байршсан мэдээллийн хүртээмжтэй байдалд Таван одны схемийн үнэлгээ хийснийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 5. СЕХ-ны албан ёсны цахим хуудсанд байрлах мэдээлэлд өгөх 5 одны үнэлгээ

Мэдээллийн нэр	Хамрах хугацаа	Мэдээллийн формат	Мэдээлэл шинэчилсэн хугацаа	5 одны схемийн үнэлгээ
Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн	1992-2016	.pdf	2017	*
Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн	1993-2017	.pdf	2017	*
Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн дүн	2016-2019	.pdf	2019	*



СЕХ-ны албан ёсны цахим хуудсанд байрлах дээрх мэдээллийг Таван одны схемээр дүгнэвэл “Нэг од” буюу мэдээлэл нь нээлттэй боловч дахин боловсруулах боломжгүй PDF хэлбэрээр байршсан байна.

1992-2016 оны Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүнгийн товчоон хэсэгт хүн амын тоо, сонгуулийн насны хүн амын тоо, нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, санал хураалтад оролцсон сонгогчдын тоо, хувь, хүчинтэй саналын хуудасны тоо, хувь зэрэг мэдээлэл улсын хэмжээнд нэгтгэсэн байдлаар тусжээ.

Хүснэгт 6. УИХ-ын сонгуулийн ирц 1992-2016⁴⁶

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТОВЧООН
(1992-2016)

№	Үзүүлэлт	1992 оны сонгууль	1996 оны сонгууль	2000 оны сонгууль	2004 оны сонгууль	2008 оны сонгууль	2012 оны сонгууль	2016 оны сонгууль	
1	Хүн амын тоо	2 154 646	2 231 363	2 382 525	2 407 568	2 564 285	2 801 136	3 057 778	
2	Сонгуулийн насны хүний тоо	1 202 704	1 218 549	1 364 862	1 472 372	1 607 825	1 882 035	1 998 823	
3	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч	1 085 129	1 147 260	1 247 033	1 279 516	1 542 617	1 840 824	1 911 047	
4	Санал өгсөн сонгогчийн	тоо	1 037 392	1 057 182	1 027 985	1 051 812	1 179 448	1 238 537	1 406 123
		хувь	95,6	92,1	82,4	82,2	76,46	67,28	73,58
5	Хүчинтэй саналын хуудасны	тоо	975 149	1 010 157	1 002 557	1 036 578	1 160 326	1 238 537	1 406 123
		хувь	94,0	95,6	97,5	98,5	98,38	100,00	100,00

Харин тойрог тус бүрээр нарийвчилж харвал нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, санал хураалтад оролцсон сонгогчдын тоо, хувь, хүчинтэй саналын хуудасны тоо, хувь зэрэг мэдээлэл (хүн амын тоо, сонгуулийн насны хүн амын тоо байхгүй) аймаг, сум тус бүрээр байна.

Хүснэгт 7. УИХ-ын сонгуулийн ирц, тойргоор⁴⁷

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 1992 ОНЫ СОНГУУЛИЙН 2 ДУГААР ТОЙРГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ДҮН
(БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ, СУМ, НЭР ДЭВШИГЧ ТУС БҮРЭЭР)

№	Үзүүлэлт	Сумд	Алтай	Алтанцөгц	Баяннуур	Бугат	Булган	Буянт	Дэлүүн	Ногооннуур	Сагсай	Толбо	Улаанжус	Цэнгэл	Цагааннуур	Өлгий хот	ДҮН
1	Нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогч		1984	1723	2802	1651	2737	1305	3955	3737	2101	2258	3562	3476	1208	12851	45350
2	Санал өгсөн сонгогчдын	тоо	1965	1692	2647	1574	2619	1232	3727	3590	2061	2223	3519	3202	1165	10916	42132
		хувь	99,4	98,20	94,47	95,34	95,69	94,41	94,24	96,07	98,10	98,45	98,79	92,12	96,44	84,94	92,90
3	Хүчинтэй саналын хуудасны	тоо	1938	1665	2498	1512	2530	1130	3150	3414	1859	2194	3379	3170	1131	9656	39226
		хувь	98,63	98,40	94,37	96,06	96,60	91,72	84,52	95,10	90,20	98,70	96,02	99,00	97,08	88,46	93,10
4	Хүчингүй саналын хуудасны	тоо	27	27	149	62	89	102	577	176	202	29	140	32	34	1260	2906
		хувь	1,60	1,60	5,63	3,94	3,40	8,28	15,48	4,90	9,80	1,30	3,98	1,00	2,92	11,54	6,90

1992 оны байдлаар нийт 26 тойргийн мэдээлэл байгаагаас Архангай, Увс аймгийнх сумдаар байхгүй, нийслэлийн 21-26 дугаар тойргийнх дүүрэг тус бүрийн задаргаа байхгүй, зөвхөн тойргийн нэгдсэн дүнгээр л ирцтэй холбоотой хэсгийг авах боломжтой байна. Харин 1996-2004 оны ирцийн мэдээллийг бүх аймаг, сумдаар, нийслэлийн ирцийн мэдээллийг тойрог бүрээр мэдээлсэн байна. 2008-2016 онд нэмэлтээр орж ирсэн өөрчлөлт гэвэл Орхон, Дархан-Уул аймгийнх болон нийслэлийнхийг хэсгийн хороодоор нарийвчлан гаргажээ. Ерөнхийлөгчийн сонгуулийн тухайд ч ирцийн мэдээллийг хүргэсэн дээрх хэлбэр яг адил байна.

⁴⁶ www.gec.gov.mn

⁴⁷ www.gec.gov.mn

Цаашлаад тус СЕХ-ны сайтын “Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн дүн” хэсгийг харвал зөвхөн 2016 оны ээлжит сонгуулийн дүн байршсан, үүнээс өмнөх дүнгүүд байхгүй байна. Энд зөвхөн санал хураалтын дүн байх ба сонгогчдын ирцийн мэдээлэл байхгүй. 2017 оноос 2019 онд явагдсан нөхөн ба дахин сонгуулийн санал хураалтын дүнтэй хамт нэрийн жагсаалтад бичигдсэн сонгогчдын тоо, санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны тоо зэрэг мэдээллүүд байна.

Зураг 9. Орон нутгийн сонгуулийн ирц⁴⁸

**2019 ОНД ЯВАГДСАН ОРОН НУТГИЙН ИТХ-ЫН НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛИЙН
САНАЛ ХУРААЛТЫН ДҮНГИЙН МЭДЭЭ**

2019.06.30

№	Аймаг	Сум	Хэсгийн дугаар	Мандатын тоо	Нарийн жагсаалтад бичигдсэн сонгогчийн тоо	Санал тоолох төхөөрөмжид уншигдсан саналын хуудасны			Санал огт тэмдэглээгүй	Нэр дэвшигчийн овог, нэр	Нэр дэвшүүлсэн субъект	Нэр дэвшигчийн төлөө өгсөн саналын	
						тоо	хувь	тоо				хувь	тоо
АЙМГИЙН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ													
1	Ховд	Мөнххайрхан	15	1	350	250	71.4	5	2.0	Басангийн БАТБОЛД	МАН	494	50.4
			16		346	236	68.2						
			17		234	191	81.6						
			18		443	305	68.8						
СУМЫН ИТХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ													
1	Баян-Өлгий	Ногооннуур	164	1	212	82	38.7		0.0	Сангийн АМАНЖОЛ	Бие даагч	82	100.0

СЕХ-ны сонгуулийн ирцийн мэдээлэл дахин боловсруулах боломжгүй өгөгдлийн формат (pdf, jpeg) болон цаасан суурьтай ном хэлбэрээр олон нийтэд хүргэж байна. Эндээс дараах асуудлууд үүсэж байна.

- Нээлттэй өгөгдлийг дэмждэггүй буюу дахин боловсруулах зорилгоор өгөгдлийг байршуулдаггүй.
- Мэдээллийг олон нийтэд хүргэх /цахим хуудас, ном хэлбэр/ тогтсон хугацаа байхгүй. Жишээ нь, Монгол
- Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгууль 2020 оны 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан ч 2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар ирцийн мэдээлэл холбогдох төрийн байгууллагуудын цахим хуудас дээр байхгүй.
- Ирцийн мэдээллийн нарийвчлал хангалтгүй. Манай улс 2012 оноос сонгуулийн автоматжуулсан систем нэвтрүүлж эхэлснээр сонгуулийн ирцийн мэдээлэл 18-25, 26-40, 41-55, 56-аас дээш гэсэн насны ангиллаар гарч байгаа. Гэсэн хэдий ч энэ насны ангилал бүхий ирцийн мэдээлэл холбогдох төрийн байгууллагуудын цахим хуудас дээр байхгүй зэрэг болно.

Үндэсний статистикийн хорооны тухайд:

ҮСХ-ны статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн “Сонгууль” цэсэд “Сонгогчдын оролцоо” гэсэн дэд сэдэвт дараах мэдээллүүд байршиж байна. Энэхүү мэдээллүүдийн хүртээмжтэй байдалд 5 одны схемийн үнэлгээ хийснийг дараах хүснэгтээс харж болно.



⁴⁸ www.gec.gov.mn



Хүснэгт 8. Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байрлах мэдээлэлд өгөх 5 одны үнэлгээ⁴⁹

Хүснэгтийн нэр	Хугацаа	Мэдээллийн формат	Мэдээлэл шинэчилсэн хугацаа	5 одны схемийн үнэлгээ
Улсын Их Хурлын сонгуулийн сонгогчдын оролцоо	1992-2016	xlsx .csv	2020-01-31	***
Орон нутгийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлын сонгуулийн сонгогчдын оролцоо	1996-2016	.txt .json	2020-01-31	***

ҮСХ-ны албан ёсны цахим хуудсанд байрлах дээрх мэдээллийг Таван одны схемээр дүгнэвэл “Гурван од” буюу тус мэдээлэл нь “xlsx, csv, txt, json” зэрэг дахин боловсруулах боломжтой хэлбэрээр байршсан байна.

УИХ-ын сонгуулийн 1992-2016 оны сонгогчдын ирцийн мэдээг (Орон нутгийнх 1996-2016 он) нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо, сонгуульд санал өгсөн хүний тоо, сонгогчдын оролцооны хувиар гаргасан байдлаар авах боломжтой байна.

Зураг 10. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн ирц 1992-2000⁵⁰

Статистик үзүүлэлт	Улс төрийн намын нэр	1992	1996	2000
Улсын Их Хурал	Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүн, мянган хүн	1,085.2	1,147.3	1,247
	Сонгуульд санал өгсөн хүн, мянган хүн	1,037.4	1,057.2	1,028
	Сонгогчдын оролцооны хувь	95.6	92.1	82.4
Орон нутгийн хурал	Нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн хүн, мянган хүн		1,061.8	1,105.4
	Сонгуульд санал өгсөн хүн, мянган хүн		765.4	728.8
	Сонгогчдын оролцооны хувь		72.1	65.9

Дээрх мэдээлэл нь дахин боловсруулах боломжтой буюу Монгол Улсад мөрдөж буй нээлттэй өгөгдлийн .xlsx, .csv, .txt, .json форматуудаар байрлуулснаараа ач холбогдолтой болжээ. Түүнчлэн өгөгдлийг олон хэлбэрээр харах боломжтой. Жишээлбэл, сонгуулийн төрлөөр сонгож харах, мөн өгөгдлийг хүснэгт, шугаман график, баганан график, талбайн график, туузан график, дугуй графикаар тус тус харах боломжтой. Гэхдээ дараах дутагдалтай тал байна.

- Зөвхөн улсын хэмжээний нэгдсэн тоо байна (Газар зүйн байрлал, насны бүлэг болон хүйсээр ангилан харах боломжгүй)
- Мэдээллийн үнэн зөв байдал хангалтгүй. СЕХ-ны цахим хуудас дээрх сонгуулийн ирц болон Статистикийн мэдээллийн сан дээрх сонгуулийн ирц зөрүүтэй тохиолдол байна. Тодруулбал Монгол Улсын ерөнхийлөгчийн сонгуулийн 2001, 2005, 2013 оны сонгуулийн ирцийн дүн зөрүүтэй байна. (Тоонууд нь мянгатын оронд шилжүүлж гаргасан тооцоолол байна)

⁴⁹ www.1212.mn

⁵⁰ www.1212.mn

Улсын бүртгэлийн ерөнхий газрын тухайд:

УБЕГ-с гаргасан ирцийн мэдээ өөрийн сайт дээр нь байршаагүй, харин бусад байгууллагын сувгууд дээр байна. Тухайлбал 2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээ нь www.ikon.mn сайтад, орон нутгийн сонгуулийн ирцийн мэдээ нь СЕХ-ны Фэйсбүүк хуудсанд тус тус нийтлэгджээ.


Www.ikon.mn сайтад нийтлэгдсэн УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээнд сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн иргэдийн тоо, нийт сонгогчийн тоо, санал өгсөн сонгогчийн тоо, хувь зэрэг мэдээллийг тойрог бүрээр, 17:00, 21:00, 22:00 цагийн байдлаар тус тус багтсан. Мөн 4 насны ангиллаар (18-25, 26-40, 41-55, 56 ба түүнээс дээш), энэ нь дотроо

- саналаа өгсөн нийт сонгогчдыг эдгээр насны бүлэгт ангилсан,
- тухайн насны бүлэг тус бүрд санал өгөх ёстой нийт сонгогчдоос хэд нь өгсөн байгааг харуулсан байдлаар гаргажээ.

Зураг 11. УИХ-ын 2020 оны сонгуулийн ирц⁵¹

Тойрог	Аймаг/Дүүрэг	Хэсгийн тоо	Сонгогчдын нэрсийн жагсаалтад бүртгэгдсэн	Тур хасав төлөвөөс сэргээсэн	Нийт сонгогчийн тоо	Санал өгсөн сонгогчийн тоо (22 цаг)	Санал өгсөн сонгогчийн хувь (22 цаг)	18-25	26-40	41-55	56 дээш	Санал өгсөн сонгогчийн тоо 22 цагийн байдлаар
1-р тойрог	АРХАНГАЙ	105	61,194	33	61,227	45,469	74.3%	7,106 (55.2%)	14,944 (72.6%)	14,369 (88.5%)	9,050 (78.7%)	45,469
2-р тойрог	БАЯН-ӨЛГИЙ	96	59,386	208	59,594	49,993	83.9%	9,845 (73.9%)	18,640 (83.0%)	13,711 (96.3%)	7,797 (83.3%)	49,993
3-р тойрог	БАЯНХОНГОР	105	56,574	36	56,610	45,318	80.1%	8,200 (69.4%)	16,295 (78.2%)	12,962 (90.6%)	7,861 (81.6%)	45,318
4-р тойрог	БУЛГАН	68	40,877	19	40,896	29,499	72.1%	3,669 (51.1%)	8,692 (67.1%)	10,062 (85.7%)	7,076 (78.6%)	29,499
5-р тойрог	ГОВЬ-АЛТАЙ	87	37,448	26	37,474	28,376	75.7%	4,869 (60.8%)	9,218 (73.5%)	9,055 (88.2%)	5,234 (79.0%)	28,376

Харин 2020 оны Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ нэгтгэн гаргасан бөгөөд Сонгуулийн ерөнхий хорооны фэйсбүүк хуудаст оруулсан байна. Үүнд үндсэн сонгогчийн тоо, нийт сонгогчийн тоо, санал өгсөн хүний тоо, хувь зэргийг аймаг, дүүрэг тус бүрээр мөн саналаа өгсөн сонгогчдыг 18-25, 26-40, 41-55, 56 ба түүнээс дээш гэсэн 4 насны ангиллаар болон хүйсээр ялган харуулжээ. Гэхдээ энэ мэдээлэл нь зураг хэлбэрээр орсон байна.



⁵¹ <https://ikon.mn/elections/2020/irts/t>



Зураг 12. Орон нутгийн сонгуулийн ирц, СЕХ фэйсбүүк хуудас

АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИТХ-ЫН 2020 ОНЫ ЭЭЛЖИТ СОНГУУЛИЙН ИРЦИЙН МЭДЭЭ - 2020.10.15

№	Аймаг, дүүргийн нэр	Үндсэн сонгогчийн тоо	Нийт сонгогчийн тоо	Санал өгсөн хүний тоо	Санал өгсөн байдлаар:				Хүйсээр:		Насаар:			Нийт сонгогчоос санал өгсөн сонгогчийн хувь	
					Хурууны хэзгээр	Хурууны хэзгээр танх бөмөгжүүлэгээс регистрийн дугаараар	"Тур хасав"-аас сэргээсэн	Зөврийн хайрцаар	Эрэгтэй	Эмэгтэй	18-25 нас	26-40 нас	41-55 нас		56 ба түүнээс дээш
1	Архангай	60 956	60 982	40 076	37 426	1 638	26	986	19 284	20 792	4 693	13 477	13 505	8 401	65.72%
2	Баян-Өлгий	59 834	59 931	48 159	45 170	2 163	97	729	23 636	24 523	7 665	18 623	13 753	8 118	80.36%
3	Баянхонгор	56 290	56 302	37 889	36 049	483	12	1 345	17 015	20 874	5 389	13 825	11 434	7 241	67.30%
4	Булган	40 591	40 621	26 102	25 120	321	30	631	12 332	13 770	2 464	7 657	9 325	6 656	64.26%
5	Говь-Алтай	37 270	37 274	25 175	23 716	844	4	611	11 688	13 489	2 989	8 608	8 612	4 966	67.54%
6	Говьсүмбэр	10 520	10 527	6 883	6 750	82	7	44	3 134	3 749	887	2 506	2 177	1 313	65.38%
7	Дархан-Уул	65 212	65 261	27 094	26 220	525	49	300	11 062	16 032	2 139	7 846	9 106	8 003	41.52%
8	Дорноговь	43 857	43 886	24 281	23 498	387	29	367	10 871	13 410	2 480	8 912	7 641	5 248	55.33%
9	Дорнод	51 204	51 245	29 273	27 990	816	41	426	13 447	15 826	2 730	10 410	9 170	6 963	57.12%
10	Дундговь	30 281	30 292	18 384	17 586	445	11	342	8 388	9 996	2 196	5 846	5 752	4 590	60.69%
11	Завхан	47 014	47 039	33 965	32 226	740	25	974	16 033	17 932	3 944	11 162	11 807	7 052	72.21%
12	Орхон	66 857	66 915	33 886	32 814	688	58	326	14 854	19 032	2 919	11 143	11 168	8 656	50.64%
13	Сэлэнгэ	69 977	70 033	41 583	40 541	510	56	476	18 767	22 816	4 345	13 030	14 103	10 105	59.38%
14	Сүхбаатар	40 337	40 354	30 537	28 847	918	17	755	14 576	15 961	3 735	11 353	9 533	5 916	75.67%
15	Төв	61 251	61 280	38 529	37 199	601	29	700	18 128	20 401	4 475	11 743	12 416	9 895	62.87%
16	Увс	51 258	51 283	36 606	35 202	697	25	682	17 662	18 944	4 699	13 244	11 936	6 727	71.38%
17	Ховд	53 815	53 864	37 684	35 225	1 427	49	983	17 778	19 906	5 004	13 432	11 972	7 276	69.96%
18	Хэнтий	49 606	49 619	31 052	29 981	473	13	585	14 582	16 470	3 708	10 097	9 976	7 271	62.58%
19	Хөвсгөл	86 096	86 143	50 910	47 605	1 014	47	2 244	22 833	28 077	4 725	17 247	17 257	11 681	59.10%
20	Өвөрхангай	73 984	74 012	42 448	40 077	771	28	1 572	18 842	23 606	4 837	13 883	14 014	9 714	57.35%
21	Өмнөговь	44 346	44 383	29 560	28 422	311	37	790	13 343	16 217	4 025	11 645	8 317	5 573	66.60%
АЙМГИЙН ДҮН		1 100 556	1 101 246	690 076	657 664	15 854	690	15 868	318 253	371 823	80 048	235 689	222 974	151 365	62.68%
22	Багануур дүүрэг	18 468	18 495	9 321	9 004	151	27	139	3 798	5 523	816	3 027	2 924	2 554	50.40%
23	Багахангай дүүрэг	2 726	2 734	2 075	2 005	27	8	35	939	1 136	333	721	563	458	75.90%
24	Баянгол дүүрэг	138 225	138 485	70 845	68 261	1 967	260	357	29 056	41 789	7 391	24 900	20 378	18 176	51.16%
25	Баянзүрх дүүрэг	226 613	226 917	105 008	101 480	2 814	304	410	44 431	60 577	12 581	37 975	30 547	23 905	46.28%
26	Налайх дүүрэг	23 664	23 700	13 646	13 107	337	36	166	5 814	7 832	1 809	4 402	3 963	3 472	57.58%
27	Сонинхоайрхан дүүрэг	197 982	198 190	91 126	87 455	2 347	208	1 116	38 313	52 813	10 981	31 235	28 345	22 565	45.98%
28	Сүхбаатар дүүрэг	88 579	88 762	45 311	42 914	1 806	183	408	19 352	25 959	5 162	14 463	12 994	12 692	51.05%
29	Хан-Уул дүүрэг	120 458	120 678	59 512	57 308	1 501	220	483	25 125	34 387	6 303	22 391	16 854	13 964	49.31%
30	Чингэлтэй дүүрэг	97 493	97 587	42 090	39 965	1 512	94	519	17 825	24 265	4 634	12 903	12 409	12 144	43.13%
НИЙСЛЭЛИЙН ДҮН		914 208	916 548	438 934	421 499	12 462	1 340	3 633	184 653	254 281	50 010	192 017	126 977	109 930	47.94%
УЛСЫН ДҮН		2 014 764	2 016 794	1 129 010	1 079 163	28 316	2 030	19 501	602 906	626 104	130 058	387 706	349 951	261 295	55.98%
Нийт сонгогчдоос эзлэх хувь					53.51%	1.40%	0.10%	0.97%	24.94%	31.04%	6.45%	19.22%	17.35%	12.96%	
Саналаа өгсөн сонгогчдоос эзлэх хувь					95.58%	2.51%	0.18%	1.73%	44.54%	55.46%	11.52%	34.34%	31.00%	23.14%	

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

УБЕГ-аас гарган танилцуулсан дээрх мэдээллүүдийн хүртээмжтэй байдалд 5 одны системийн үнэлгээ хийснийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 9. 2020 оны УИХ, Орон нутгийн сонгуулийн дүнг мэдээлсэн байдалд өгөх 5 одны үнэлгээ

Хүснэгтийн нэр	Хугацаа	Мэдээллийн формат	Мэдээлэл шинэчилсэн хугацаа	5 одны схемийн үнэлгээ
УИХ-ын сонгуулийн ирц	2020	Газрын зураг, Хүснэгт	2020.06.25	*
Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн сонгогчдын оролцоо	2020	.jpeg	2020-10-19	*

Таван одны схемээр дүгнэвэл “Нэг од” буюу мэдээлэл нь нээлттэй боловч дахин боловсруулах боломжгүй хэлбэрээр байршсан байна.

СЕХ, ҮСХ, УБЕГ зэрэг байгууллагууд сонгуулийн ирцийн мэдээллийг тухайн сонгууль явагдаж дууссанаас хойш хэдий хугацаанд олон нийтэд ил тод болгох тухай тодорхой дүрэм, журам байхгүй.

Мөн иргэд, судлаачид дээрх мэдээллийг авахыг хүсвэл хаашаа хандаж, ямар өргөдөл хүсэлт гаргаж байж (эсвэл худалдаж авах) тухайн мэдээллийг авах процесс тодорхойгүй. Тухайн мэдээллийг олон нийтэд ил тод тавих тухай зохицуулалт ч байхгүй байна.

Одоо байгаа ирцийн өгөгдөлд тулгуурлан ямар дүн шинжилгээ хийх боломжтой байна вэ?

СЕХ-ны цахим хуудсанд PDF хэлбэрээр байрлах Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн 1992-2016, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн 1993-2017 эмхэтгэлийн ирцийн мэдээлэл, ҮСХ-ны Статистикийн мэдээллийн сан /www.1212.mn/-н сонгуулийн ирцийн мэдээлэлд дараах дүн шинжилгээг хийх боломжтой байна.

1. 1992-2016 оны УИХ-ын болон 1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үед сонгогчдын нэрийн жагсаалтад хэдэн хүн бичигдсэн байсан, тэдний хэд нь сонгуульд оролцож саналаа өгсөн, эдгээр нь сонгуулийн насны хүн амын болон нийт хүн амын хэдэн хувийг эзэлж байв (зөвхөн улсын хэмжээнд, тойрог, аймаг, нийслэл, дүүргээр гарахгүй)
2. 1992-2016 оны УИХ-ын болон 1993-2017 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн үед сонгогчдын нэрийн жагсаалтад хэдэн хүн бичигдсэн байсан, тэдний хэд нь сонгуульд оролцож саналаа өгөв хэмээх тооцооллыг аймаг, сум тус бүрээр гаргах боломжтой байна. (Гэхдээ нийслэлийн дүүргүүдээр боломжгүй)
3. Аль нэг аймгийн УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулийн оролцоог 1992-2020 (1993-2017) гаргах боломжтой.
4. Орон нутгийн сонгуулийн ирцийг нэрийн жагсаалтад бүртгэгдсэн сонгогчийн тоо, сонгуульд санал өгсөн сонгогчийн тоо, сонгогчдын оролцооны хувиар гарган харуулах боломжтой. Гэхдээ энэ нь зөвхөн улсын хэмжээнд боломжтой байна.

Эндээс дүгнэвэл, **зөвхөн улсын хэмжээнд сонгууль бүрээр сонгогчдын ирц хэдэн хувьтай байж ирснийг, мөн аймгуудаар ангилж, ялгах гэх мэт хязгаарлагдмал боломжтой** байгаа нь харагдаж байна.

2020 оны орон нутгийн сонгуулийн ирцийн мэдээллийг үндэслэн дараах нэмэлт дүн шинжилгээг хийх боломжтой байна.⁵²

1. Улсын болон аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд саналаа өгсөн нийт сонгогчдын хүйсийн харьцаа
2. Улсын болон аймаг, нийслэл, дүүргийн хэмжээнд саналаа өгсөн нийт сонгогчдын насны бүлгийн харьцаа

Тэгвэл 2020 оны УИХ-ын сонгуулийн ирцийн мэдээллийг үндэслэн⁵³ дээрх дээр нэмэгдээд улсын хэмжээнд болон тойрог бүрд (аймаг, нийслэл, дүүрэг) дээрх насны бүлгийн саналаа өгөх ёстой сонгогчдоос хэдэн хувь нь саналаа өгснийг тооцох боломжтой байна.

⁵² Сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ гаргасан бөгөөд зураг хэлбэрээр СЕХ-ны фэйсбүүк хуудсанд байршсан

⁵³ www.ikon.mn дээр байршсан тус ирцийн мэдээг УБЕГ гаргасан бөгөөд сайт дээрээс эх датаг нь цаашид боловсруулахад тохиромжтой хэлбэрээр авах боломжтой.

Ардчилсан сонгуулийн нэг чухал зарчим бол сонгууль бүх нийтийн байх явдал билээ. Иймээс сонгогч бүрийг сонгуульд оролцож, саналаа өгөх боломжоор хангах нь чухал юм. Сонгогчдын оролцоо өсөх, буурахад маш олон хүчин зүйлс нөлөөлдөг. Боловсролын түвшин, эдийн засгийн үзүүлэлт, амьжиргааны түвшин, сонгуулийн зохион байгуулалт, сонгуулийн тогтолцоо, улс төрийн сонирхол, сонгогчдын нас, газар зүйн байршил гэх мэт. **Сонгогчдын ирц, оролцоог нэмэгдүүлэхийн тулд дээрх хүчин зүйлүүдийн нөлөөг тодорхойлж, авч болох арга хэмжээ, бодлогын өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүний тулд сонгогчдын ирцийн мэдээллийг нас, хүйс, газар зүйн байршлаар илүү нарийвчлалтай ангилахаас эхлүүлээд статистикийн үндсэн үзүүлэлтүүдтэй харьцуулан судлах зайлшгүй шаардлагатай юм.**

Ирцийг мэдээлж буй одоогийн насны бүлэг нь ҮСХ-ны статистик мэдээллийн насны бүлгээс ялгаатай байна. Энэ нь тус төрлийн мэдээлэлтэй харьцуулсан шинжилгээ хийх боломжгүй болгож байна. (Хүснэгт 10)

Хүснэгт 10. Хүн амын статистик үзүүлэлтийн насны ангилал болон сонгуулийн ирцийн мэдээллийн насны ангилал, тэдгээрийн зөрүү

Хүн амын статистик үзүүлэлтийн насны бүлэг	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Сонгуулийн ирцийн насны бүлэг /одоо байгаагаар/	18-25		26-40			41-55				56+		
Хамрах жилийн хүрээ	8		15			15					-	

Сонгогчийн ирцийн мэдээллийг гаргадаг 18-25, 26-40, 41-55, 56-аас дээш гэсэн насны ангиллыг ҮСХ-ны насны ангилалтай ижил бүлэглэж гаргах шаардлагатай байна. (Хүснэгт 9)

Хүснэгт 11. Хүн амын статистик үзүүлэлтийн насны ангилалд нийцүүлэн сонгуулийн ирцийн мэдээллийн насны ангиллыг дахин тодорхойлох санал

Хүн амын статистик үзүүлэлтийн насны бүлэг	15-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Сонгуулийн ирцийн насны бүлэг /одоо байгаагаар/	18-19	20-24	25-29	30-34	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Хамрах насны хүрээ	2	5	5	5	5	5	5	5	5	5	5	-

Дээрх хэлбэрээр ангилсан тохиолдолд дахин нэг өөрчлөлтийг хийх хэрэгцээ үүснэ. Энэ нь ҮСХ-ны насны бүлэгт байгаа 15-19 насны хэсэг юм. ҮСХ-ны зүгээс сонгуулийн ирцийн мэдээлэлтэй нийгэм эдийн засгийн зарим мэдээллийг харьцуулахын тулд 18-19 насыг тусад нь ялган харах боломжийг бүрдүүлбэл зүйтэй санагдана.



ГУРАВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Сонгогчдын бүртгэл (сонгуулийн ирц)-ийн өнөөгийн нөхцөл байдалд үнэлгээ хийсний үндсэн дээр дараах дүгнэлтэд хүрч байна.

- Монгол Улс сонгогчдын бүртгэлээ иргэний бүртгэлд үндэслэн, сонгуулийн үеэр сонгогчдын нэрийн жагсаалт гаргах байдлаар явуулж байна. Сонгуулийн жилд явагддаг нэг удаагийн шинж бүхий уг үйл ажиллагаа нь сонгогч сонгох эрхээ бүрэн дүүрэн эдлэх (нэрийн жагсаалтад бичигдэх) нөхцөлийг хангаж буй эсэх нь эргэлзээтэй, ил тод бус зэрэг сул талтай байна. Тиймээс **сонгогчдын бүртгэлийн байнгын (тасралтгүй) тогтолцоог бий болгож, тогтмол шинэчлэгддэг байх жишигт шилжих** нь сонгууль үнэн зөв, бодит бүртгэлд үндэслэн явагдах боломжийг бүрдүүлэх, сонгогчдын бүртгэлийн мэдээллийн сангийн ерөнхий мэдээллүүдийг олон нийтэд нээлттэй байршуулах боломжийг давхар бий болгох давуу талтай гэж үзэж байна.
- Сонгуулийн санал хураахаас өмнөх үе, санал хураалтын өдөр болон санал хураалт дууссаны дараах үеүдэд сонгогчийн ирц, бүртгэлтэй холбоотой мэдээ, мэдээллийг түгээх, нийтэд нээлттэй байршуулах үйл ажиллагааг зохицуулж буй **хууль тогтоомж, дүрэм, журмуудад зарим харилцааг нарийвчлан тусгах шаардлагатай** байна. Тухайлбал, сонгуулийн ирцийн мэдээг УБЕГ болон СЕХ нь өөр өөрийн нэгжээр дамжуулан авдаг, аль байгууллага нь мэдээг албан ёсоор нэгтгэх, зарлах тухай, мөн хоёр байгууллагын мэдээнд зөрүү гарсан тохиолдолд хэрхэн шийдвэрлэх тухай эрх зүйн зохицуулалт байдаггүй.
- Дээрхээс улбаалж, сонгуулийг зохион байгуулахад оролцож буй байгууллагуудын **чиг үүргийг давхардуулалгүй тодорхой болгох** шаардлагатай нь мөн харагдаж байна.
- Олон нийтийн зүгээс сонгуулийн санал хураахаас өмнө өөрийн болон гэр бүлийн гишүүдийн, мөн өөрийн хаяг дээр бүртгэлтэй хүмүүсийн мэдээлэлтэй танилцах, санал хураалтын өдөр тойргийн хэмжээний ирцийн мэдээтэй танилцах, санал хураалт дууссанаас хойш ирцийн мэдээг нэгдсэн байдлаар авах боломжтой буюу энэ төрлийн мэдээлэл **харьцангуй ил тод** байна. Гэхдээ ирцийн мэдээлэл нь нас, хүйс, зарим тохиолдолд газар зүйн байршил зэргээр нарийвчлан дүн шинжилгээ хийх боломжгүй, статистикийн бусад мэдээлэлтэй ижил түвшинд харьцуулалт хийх боломжгүй, **хүртээмжгүй, нээлттэй өгөгдлийн шалгуурыг хангаж чадахгүй** байна.

ЗӨВЛӨМЖ

Сонгогчдын бүртгэл (сонгуулийн ирц)-ийн өнөөгийн нөхцөл байдалд хийсэн үнэлгээнд тулгуурлан дараах тулгуурлан дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд,

1. **Шаардлагатай хууль, эрх зүйн баримт бичгүүдэд өөрчлөлт хийх замаар сонгогчдын бүртгэлийн байнгын (тасралтгүй) тогтолцоог бий болгож, тогтмол шинэчлэгддэг жишигт шилжих,**⁵⁴
2. **Сонгогчдын бүртгэлтэй холбоотой (нэрийн жагсаалт үйлдэх, шинэчлэх) үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллагуудын чиг үүргийг дараах байдлаар шинэчилж,**⁵⁵ **эрх зүйн баримт бичгүүдэд нарийвчлан тусгах. Үүнд,**

УБЕГ

- Сонгогчдын бүртгэлийг хийх, нэрийн жагсаалтыг үйлдэх, шинэчлэх, сонгуулийн өмнө, сонгуулийн өдөр, сонгуулийн дараа ирцийг олон нийтэд танилцуулах, баталгаажуулахад СЕХ-ны оролцоогүйгээр үндсэн үүрэгтэй ажиллах,
- Бүртгэл, ирцийн мэдээллийг дахин боловсруулалт хийх боломжтой хувилбараар эцэслэн гаргаж, ҮСХ-д шилжүүлэх,
- Сонгогчдын нэрийн жагсаалтыг шинэчлэхийн тулд УДШ, БХЯ, ШШГЕГ, ЦЕГ, ХХЕГ, ГИХГ зэрэг байгууллагуудаас холбогдох иргэний мэдээллийг СЕХ-р дамжуулалгүйгээр сонгуулийн бус жилд нэг удаа, харин сонгуулийн жилд сонгуулийн өмнө хуульд заасан нөхцөлөөр авах,

ҮСХ

- Сонгуулийн болон сонгуулийн бус жилд санал өгөх эрх бүхий сонгогчид, мөн санал өгөх эрхээ хасуулсан сонгогчдын статистикийг нас, хүйс, байршлаар тогтмол мэдээлдэг болох,
- Ирц, бусад статистик мэдээллийг харьцуулан дүн шинжилгээ хийх боломжоор хангах үүднээс нэг талбарт (мэдээллийн нэгдсэн сан) байршуулах ажлыг эрхлэх

СЕХ

- Сонгуулиудыг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллах чиг үүргээ хадгална.

3. **Сонгуулийн ирцийн мэдээг санал хурааж эхэлснээс хойш цаг бүрд олон нийтэд мэдээлж байх,** (Жишээлбэл сонгуулийн санал хураалт 8:00 цагт эхлэхэд ирцийн мэдээ 9:00 цагаас эхлээд цаг бүр гарч байх) Санал авах хэсэг бүрд ажиллах УБЕГ-ын итгэмжлэгдсэн ажилтан иргэний бүртгэлийг хариуцаж, хурууны хээгээр таниулж, сонгогчдын мэдээллийг тулгадаг. Тэр мэдээллийн баазаас шууд таталт хийх, эсвэл тойргийн хороонд төвлөрүүлээд, тэндээс шууд тодорхой цагийн горимоор татаж, олон нийтэд танилцуулах боломжтой. Тус мэдээллийг УБЕГ нь СЕХ-ны байранд танилцуулах, эсвэл технологийн байгууллагуудтай хамтран цахимаар шууд дамжуулах боломжтой.
4. **Сонгуулийн хуулиуд, холбогдох журмуудаар сонгогчдын нэрийн жагсаалт, сонгуулийн санал хураах өдрийн ирцийн мэдээллийг иргэн, олон нийт, улс төрийн нам, эвсэлд хуулийн хүрээнд мэдээлэл авах боломжоор хангах. Үүнд:**
 - Сонгуулийн өмнө улсын хэмжээнд болон тойрог бүрд сонгуулийн эрхтэй сонгогчдын тоог насны бүлэг, хүйс болон газар зүйн байршлаар (эсвэл засаг захиргааны нэгжээр) мэдээлж байх,

⁵⁴ Хавсралт 6-аас тайлбар зураглалыг үзнэ үү

⁵⁵ Хавсралт 7-оос тайлбар зураглалыг үзнэ үү

- Сонгогчдын насны бүлгийг одоо байгаа 18-25, 26-40, 41-55, 56-с дээш гэсэн өргөн хүрээнд бус 18-19, 20-24, 25-29, 30-34, 35-39, 40-44, 45-49, 50-54, 55-59, 60-64, 65-69, 70-с дээш гэсэн аль болох бага алхмаар тодорхойлох.
 - Дээрх насны бүлэг тус бүрд санал өгөх ёстой нийт сонгогчдоос хэд нь саналаа өгсөн байгааг харуулах боломжтой байх. Ингэснээр сонгогчийн сонгуулийн оролцоонд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, оролцоог сайжруулах оновчтой төлөвлөлт, шийдэл гаргах, ҮСХ-ны статистикийн бусад үзүүлэлтүүдтэй харьцуулах боломжтой болно.
5. Монгол Улсын нэгдэн орсон Нээлттэй засаг түншлэл, ухаалаг засаг төслийн хүрээнд ҮСХ болон УБЕГ нээлттэй өгөгдлийг дэмжиж, ардчилсан сонгуульд оролцогч талуудыг хүртээмжтэй, үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллээр хангах зорилгоор сонгуулийн насны иргэдийн тоон мэдээллийг нээлттэй өгөгдлийн форматаар www.1212.mn сайтад байрлуулах,
6. Сонгогчдын боловсролыг дээшлүүлэх, сонгуулийн оролцоог нэмэгдүүлэх асуудалд төрийн болон төрийн бус байгууллагуудын дэмжлэгийг илүү бодитой хэрэгтэй хэсэгт хүргэх үүднээс ирцийг дахин боловсруулах боломжтой, нээлттэй өгөгдлийн форматаар байрлуулах, мөн эдгээр мэдээллийг тогтсон хугацаанд (сонгуулийн бус жилд нэг удаа, сонгуулийн жилд сонгууль зохион байгуулагдахаас өмнө) тогтмол шинэчлэгдэх, үнэн зөв, бүрэн гүйцэд байх шаардлагыг хангах зэрэг болно.

ХАВСРАЛТ

1. 2021 оны 1 дүгээр сарын 15-ны байдлаар Монгол Улсын сонгуулийн эрх зүйн харилцааг зохицуулсан, хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 7 хууль, тэдгээрт нийцүүлэн гаргасан 15 хэм хэмжээний акт (журам) байна.

№ Хуулийн нэр	Батлагдсан он	Хүчинтэй эсэх
1. Сонгуулийн төв байгууллагын тухай	2006-01-12	Хүчинтэй
2. Сонгуулийн автоматжуулсан системийн тухай	2011-11-10	Хүчинтэй
3. Сонгуулийн тухай	2015-12-25	Хүчинтэй
4. Ард нийтийн санал асуулгын тухай	2016-02-05	Хүчинтэй
5. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай	2019-12-20	Хүчинтэй
6. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн сонгуулийн тухай	2020-01-30	Хүчинтэй
7. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай	2020-12-24	Хүчинтэй

Журмын нэр	Батлагдсан байгууллага	Батлагдсан он	Хүчинтэй эсэх
1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын “Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам	Улсын бүртгэлийн ерөнхий газар	2020	Хүчинтэй
2. Цахим орчин ашиглан сонгуулийн сурталчилгаа явуулах, түүнд хяналт тавих журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
3. Төрийн бус байгууллага сонгуулийн үйл ажиллагаанд хяналт, ажиглалт, хөндлөнгийн хяналт хийх журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
4. Сонгуулийн баримт бичгийг бүртгэх журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
5. Сонгуулийн хороонд ажиллах ажилтны сургалт зохион байгуулах, гэрчилгээ олгох журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
6. Сонгуулийн хорооны хуралдааны дэг, тэмдэглэл хөтлөх журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
7. Мэдээллийн технологийн багийн гишүүн, даамалд сургалт явуулах, гэрчилгээ олгох журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
8. Сонгууль ажиглах журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
9. Сонгогчийн саналыг зөврийн битүүмжилсэн саналын хайрцагаар авах журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
10. Саналын хуудсыг хэвлүүлэх, хүргүүлэх, хадгалах, хамгаалах журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
11. Радио, телевизээр сонгуулийн сурталчилгаа нэвтрүүлэх, хяналт тавих журам	СЕХ болон Харилцаа холбооны зохицуулах хороо	2020	Хүчинтэй
12. Нам, эвслийн сонгууль эрхэлсэн байгууллагын ажилтан, нэр дэвшигчийн менежер, шадар туслагч, ухуулагчийг бүртгэх, үнэмлэх олгох журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй

13. Хяналтын тооллого хийх журам	Сонгуулийн ерөнхий хороо	2020	Хүчинтэй
14. Монгол Улсын Их Хурлын Сонгуульд оролцож байгаа нам, эвсэл, нэр дэвшигч сонгуулийн зардлын тайлан гаргах, сонгуулийн зардлын тайланд аудит хийх, хянах, дүнг нийтэд мэдээлэх, танилцуулах журам	Монгол Улсын Засгийн газар	2020	Хүчинтэй
15. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн үйл ажиллагааны үед коронавируст халдвар (ковид-19)-аас сэргийлэх	Монгол Улсын Засгийн газар	2020	Хүчинтэй

2. Монгол Улсад нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх үйл явц

Монгол Улсад нээлттэй өгөгдлийг хөгжүүлэх, нээлттэй өгөгдлийн үндэсний хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэхэд урьдач ажил болгон Нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээг (Open Data Readiness Assessment) Дэлхийн Банкны Олон улсын ассоциацийн хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Ухаалаг засаг” төслийн хүрээнд хийж гүйцэтгэсэн. Үнэлгээний тайланд дурдсанаар мэдээллийг олон нийтэд хүргэж буй төрийн байгууллагын олон нийтэд хүргэж буй өгөгдлийг 5 одны схемээр дүгнэсэн байна. Үүнд нийт 18 байгууллагын 32 төрлийн өгөгдөл үнэлгээ хийхэд 3 одтой 3, 2 одтой 2, үлдсэн 17 өгөгдөл 1 одтой⁵⁶ үнэлэгдсэн байна. Ухаалаг засаг төслийн хүрээнд дээрх үнэлгээний дүгнэлт дээр үндэслэн “Нээлттэй өгөгдлийн тухай” хуулийн төсөл боловсруулагдаад байна.

Түүнчлэн “Ухаалаг засаг” төслийн хүрээнд Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн портал “OPENDATA.GOV.MN” ажиллуулж эхлээд байна. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд 13 байгууллагын 105 төрлийн өгөгдөл нээлттэй, үнэ төлбөргүй байршсан байна /2020 оны 12 сарын байдлаар/. Эдгээр өгөгдөл нь нээлттэй өгөгдлийн бодлогын чиглэлд тодорхойлсон формат буюу дараах төрлийн өгөгдлийн форматаар байрлаж байна.

XLSX Хүснэгт дэх мэдээлэл буюу Microsoft Excel програмаар үүсэх уг формат нь өгөгдөл, мэдээлэлд хамгийн түгээмэл хэрэглэгддэг төрөл бөгөөд энгийн түвшинд хэрэглэхэд хялбар, ойлгомжтой.


JSON формат нь дурын програмчлалын хэлэнд уншигдах энгийн болоод хялбар форматуудын нэг юм. XML зэрэг форматтай харьцуулахад хэрэглэхэд харьцангуй хялбар бөгөөд өгөгдөл, мэдээлэлд боловсруулалт хийхэд илүү дөхөм.

XML нь өгөгдөл солилцоход хамгийн ихээр хэрэглэгддэг формат бөгөөд өгөгдөл, мэдээллийг үүсгэхэд буюу буй болгосон файлын бүтцийг ямар нэгэн байдлаар өөрчилдөггүй давуу талтай.

CSV файл нь хэрэглээнд туйлын тохиромжтой форматын нэгт зүй ёсоор тооцогдох бөгөөд өгөгдөл, мэдээлэл орох, гарах бүтэц бүхий энэхүү формат нь тодорхой бүтэц бүрэлдэхүүнтэй их хэмжээний өгөгдлийг шилжүүлэх, зөөвөрлөхөд тохиромжтой.

Манай улс нээлттэй өгөгдлийг бий болгох замд эргэлт буцалтгүйгээр нэгдэн орсон нь тодорхой бөгөөд үүнийг олон салбарт нэвтрүүлэн ажилласнаар давуу талуудыг бий болох боломжтой.

Дэлхийн 114⁵⁷ улс нээлттэй өгөгдлийг дэмжиж, бий болгон ажиллаж байна. Канад, Франц, Бүгд найрамдах Солонгос, Англи, Япон, Мексик, Америк, Хятад, Сингапур, Эстони зэрэг улс орнууд нээлттэй өгөгдлийг амжилттай нэвтрүүлсэн улс оронд албан ёсоор ордог⁵⁸. Төрийн байгууллагын нээлттэй өгөгдөл дараах ерөнхий шаардлагыг хангасан байна: 1. нээлттэй, хандахад хялбар байх, 2. машин уншигдахуйц байх; 3. үнэ төлбөргүй байх, 4. тогтмол шинэчлэгддэг байх, 5. үнэн зөв, бүрэн бүтэн байх; 6. тогтвортой байх, 7. хэрэгцээтэй/ ач холбогдолтой байх.



ОИН.МН
СНЛАДГААНЫСАН

Нээлттэй өгөгдлийг бий болгосон улс орнууд
2018 он /цагаанаар тэмдэглэсэн улсууд үүнд
орохгүй/

⁵⁶ Монгол улсын нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ, 70 дугаар тал

⁵⁷ OpenData Barometer, Global Report, 2017

⁵⁸ OpenData Barometer, Global Report, 2017

3. Сонгогчдын нэрийн жагсаалтыг танилцуулах, хүргүүлэх, өөрчлөлт оруулах харилцааг зохицуулсан заалтууд


Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам /УБЕГ-ын даргын А/372 дугаар тушаал/ /2020.03.24/-ын судалгааны хүрээнд холбогдох заалтууд

Зүйл хэсэг	Заалт хэсэг
2.1	Улсын бүртгэлийн байгууллагын орон нутаг дахь хэлтэс Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсэгт заасны дагуу ирүүлсэн сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолд заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэр, төвийн мэдээллийг иргэний улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь сонгогчдын бүртгэлд тусгана.
2.2	Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.1-д заасан мэдээллийг 5 хоногийн дотор нэгтгэн сонгуулийн хэсэг байгуулсан тухай сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолын эх хувийн хамт улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.
2.3	Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.2-т заасан мэдээллийг үндэслэн цахим санд сонгуулийн хэсгийг улсын хэмжээнд давхардахгүй байхаар дугаарлана.
2.4	Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.3-т заасан сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй, тухайн сонгуулийн хэсэгт хамаарах сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдэх сонгуулийн насны иргэдийн мэдээллийг цахим санд оруулна.
2.9	Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.7-д заасны дагуу холбогдох мэдээллийг нягтлан шалгасны дараа сонгогчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, нас хүйс, регистрийн дугаар, байнга оршин суугаа газрын хаяг гэсэн дарааллаар аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хороо болон сонгуулийн хэсэг тус бүрээр нэгтгэн сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэнэ.
3.1	Төрийн захиргааны байгууллага энэ журмын 2.9-д заасны дагуу үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг ээлжит сонгуулийн жилийн 04 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тухайн сонгууль дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.
3.2	Төрийн захиргааны байгууллага энэ журмын 3.1-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудас байршуулахдаа тухайн сонгогч өөрийн регистрийн дугаарыг ашиглан сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжийг хангасан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам /УБЕГ А961/ -ын судалгааны хүрээнд холбогдох заалтууд

Зүйл хэсэг	Заалт хэсэг
3.1	Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж энэ журмын 2.8-д заасны дагуу үйлдсэн сонгогчдын нэрийн жагсаалтыг санал авах өдрөөс 90-ээс доошгүй хоногийн өмнөөс эхэлж аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгууль дуустал өөрийн байгууллагын цахим хуудаст байршуулна.
3.2	Мэдээллийн технологийн асуудал хариуцсан нэгж энэ журмын 3.1-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтыг цахим хуудаст байршуулахдаа тухайн сонгогчийг сонгогчдын нэрийн жагсаалт дахь өөрт холбогдох мэдээлэлтэй танилцах боломжийг хангасан байна.
3.4	Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 2.8-д заасан сонгогчдын нэрийн жагсаалтын холбогдох мэдээлэлд Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.9.1-20.9.4 дэх заалтад заасан өөрчлөлтийг цахим санд тусгана.
3.7	Улсын бүртгэлийн хэлтэс, итгэмжлэгдсэн ажилтан энэ журмын 3.4-т заасан өөрчлөлтөөс гадна дараах өөрчлөлтийг Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу санал авах өдрөөс 3-аас доошгүй хоногийн өмнө цахим санд тусгаж, энэ тухай итгэмжлэгдсэн ажилтан Улсын бүртгэлийн хэлтэст, Улсын бүртгэлийн хэлтэс иргэний улсын бүртгэлийн асуудал хариуцсан нэгжид мэдэгдэнэ.
3.7.1	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан гомдлын дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдээгүй, сонгуулийн хэсгийн нутаг дэвсгэрт байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлтэй сонгуулийн эрх бүхий иргэнийг нэмсэн өөрчлөлт;
3.7.2	Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт заасан гомдлын дагуу сонгогчдын нэрийн жагсаалтад буруу бүртгэсэн сонгогчийн мэдээллийг
3.8	Иргэний улсын бүртгэлийн цахим сангийн мэдээлэл, эх нотлох баримтыг үндэслэсэн өөрчлөлт. Улсын бүртгэлийн хэлтэс энэ журмын 3.7-д заасан мэдээллийг үндэслэн “Сонгогчдын нэрийн жагсаалтад өөрчлөлт оруулах тухай лавлагаа -Маягт 4” -г хэвлэж, итгэмжлэгдсэн ажилтанд нэн даруй мэдээлнэ.
3.9	Энэ журмын 3.6-д заасны дагуу итгэмжлэгдсэн ажилтанд хүргүүлсэн сонгогчдын нэрийн жагсаалтад тухайн итгэмжлэгдсэн ажилтны тэмдэглэсэн өөрчлөлт нь энэ журмын 3.8-д заасны дагуу Улсын бүртгэлийн хэлтсийн хэвлэсэн лавлагааны тоотой тэнцүү байна.


4. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэх, ирцийн мэдээг танилцуулах, баталгаажуулах зураглал



5. Сонгогчдын бүртгэл, ирцийн мэдээллийн ил тод байдлын үнэлгээ (товч)


	Сонгогчдын бүртгэл, нэрийн жагсаалттай холбоотой үйл ажиллагаа	Хариуцах байгууллага	Тайлбар	Үнэлгээ
Сонгуулийн санал авах өдрөөс өмнө	Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх	УБЕГ	Сонгогч зөвхөн өөрийн хувийн мэдээлэлтэй цахимаар танилцах, засвар оруулах боломж олгосон.	Олон нийтэд сонгуулийн эрх бүхий хэдэн сонгогч байгаа мэдээлэл, нас, хүйс, тойргоор хаалттай
	Сонгогчдын нэрийн жагсаалтыг нягтлан шалгах,	УБЕГ		
	Сонгогчдын нэрийн жагсаалтын давхардлыг арилгах,бүртгэх,	УБЕГ	СЕХ холбогдох төрийн байгууллагаас хуульд заасан хугацаанд мэдээллийг авч давхардлыг арилгасан.	
	Сонгогчдын нэрийн жагсаалттай холбоотой гомдлыг шийдвэрлэх	УБЕГ Хэсгийн хороо	Сонгогч зөвхөн өөрийн хувийн мэдээлэлтэй цаасаар танилцах, засвар оруулах боломж олгосон.	
	Сонгуульд өрсөлдөж байгаа нам, эвслийн итгэмжлэгдсэн төлөөлөгч хүсэл гаргавал өгнө.	УБЕГ	Сонгуульд өрсөлдөж буй нам, эвсэлд нэг удаа цахим хэлбэрээр сонгогчдын нэрийн жагсаалтыг хувилахгүй, тараахгүй байх нөхцөлтэй өгсөн.	
Сонгуулийн санал авах өдөр	Сонгогчдын ирцийг мэдээлэх	Тодорхойгүй	СЕХ мэдээллийг цуглуулах ажлыг журмаар зохицуулж, сонгуулийн өдөр олон нийтэд сонгогчдын ирцийн мэдээллийг өгсөн.	Сонгуулийн эрх бүхий хэдэн сонгогч байгаа мэдээлэл, нас, хүйсийн мэдээлэл хагас хаалттай
Сонгуулийн санал авах ажиллагаа	Сонгуулийн дүнг баталгаажуулах	Тодорхойгүй.	СЕХ дүнг нэгтгэж, мандатын тоотой тэнцүү хамгийн олон санал авсан нэр дэвшигчийг УИХ-ын гишүүнээр сонгогдсонд тооцож, үнэмлэх олгож, нийтэд мэдээлэл өгсөн.	Олон нийтэд сонгуулийн эрх бүхий хэдэн сонгогч байгаа, хэдэн сонгогч оролцсон мэдээлэл, нас, хүйс, тойргоор хаалттай
	Дүнг нэгтгэж, мэдээлэх	СЕХ		

6. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд оролцогч байгууллагууд






7. Одоогийн сонгогчдын бүртгэл, ирцийн мэдээллийг түгээх тогтолцоо



Санал болгож буй сонгогчдын бүртгэл, ирцийн мэдээллийг түгээх тогтолцоо



ХҮСНЭГТ, ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, нягтлан шалгах, давхардал, зөрчлийг арилгах, танилцуулах тухай журам батлах хуулийн зохицуулалтууд

Хүснэгт 2. Сонгуулийн насны иргэд ба сонгогчдын нэрийн жагсаалт

Хүснэгт 3. Гадаад улсад оршин сууж байхдаа саналаа өгсөн сонгогчдын тоо

Хүснэгт 4. Сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн, саналаа өгсөн сонгогчдын тоо (мянган хүн)

Хүснэгт 5. СЕХ-ны албан ёсны цахим хуудсанд байрлах мэдээлэлд өгөх 5 одны үнэлгээ

Хүснэгт 6. УИХ-ын сонгуулийн ирц 1992-2006

Хүснэгт 7. УИХ-ын сонгуулийн ирц, тойргоор

Хүснэгт 8. Статистикийн мэдээллийн нэгдсэн санд байрлах мэдээлэлд өгөх 5 одны үнэлгээ

Хүснэгт 9. 2020 оны УИХ, Орон нутгийн сонгуулийн дүнг мэдээлсэн байдалд өгөх 5 одны үнэлгээ

Хүснэгт 10. Хүн амын статистик үзүүлэлтийн насны ангилал болон сонгуулийн ирцийн мэдээллийн насны ангилал, тэдгээрийн зөрүү

Хүснэгт 11. Хүн амын статистик үзүүлэлтийн насны ангилалд нийцүүлэн сонгуулийн ирцийн мэдээллийн насны ангиллыг дахин тодорхойлох санал

Зураг 1. Нээлттэй өгөгдлийг түгээх таван одны схем

Зураг 2. УИХ-ын болон Ерөнхийлөгчийн сонгуулиудын нэрийн жагсаалтад бичигдээгүй сонгогчийн тоон зөрүү, хувиар

Зураг 3. Сонгогчдын нэрийн жагсаалтыг үйлдэхэд оролцогч байгууллагууд

Зураг 4. Маягт 1. (.... сонгуулийн санал хураалтын ирцийн мэдээ)

Зураг 5. Маягт 2. (.... сонгуулийн ... дугаар тойргийн санал хураалтын дүнгийн нэгтгэл)

Зураг 6. 2020 оны УИХ-ын сонгуулийн ирц (Улсын хэмжээнд)

Зураг 7. 2020 оны УИХ-ын сонгуулийн ирц (Хөвсгөл аймгийн хэмжээнд)

Зураг 8. УИХ-ын 2020 оны сонгуулийн ирц (Аймаг, тойргоор)

Зураг 9. Орон нутгийн сонгуулийн ирц

Зураг 10. УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн ирц 1992-2000

Зураг 11. УИХ-ын 2020 оны сонгуулийн ирц

Зураг 12. Орон нутгийн сонгуулийн ирц, СЕХ фэйсбүүк хуудас

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Монгол Улсын Үндсэн хууль. 1992 он.
<https://www.legalinfo.mn/law/details/367>
2. Монгол улсын их хурлын сонгуулийн тухай хууль. 2019 он.
<https://www.legalinfo.mn/law/details/14869>
3. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хууль. 2020 он.
<https://legalinfo.mn/law/details/15826?lawid=15826>
4. Аймаг нийслэл, сум дүүргийн ИТХ-ын тухай сонгуулийн хууль. 2020 он.
<https://www.legalinfo.mn/law/details/15125?lawid=15125>
5. Иргэний улсын бүртгэлийн тухай хууль. 2018 он.
<https://www.legalinfo.mn/law/details/13540?lawid=13540>
6. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль. 2011 он.
<https://legalinfo.mn/law/details/374?lawid=374>
7. Шилэн дансны тухай хууль. 2014 он.
<https://legalinfo.mn/law/details/10497?lawid=10497>
8. Монгол Улсын Үндэсний Аюулгүй байдлын үзэл баримтлал (2010)
<http://www.nsc.gov.mn/sites/default/files/National%20Security%20Concept%20of%20Mongolia%20MN.pdf>
9. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын сонгуулийн сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, танилцуулах, хүргүүлэх журам. УБЕГ. 2020 он.
<https://burtgel.gov.mn/post/43958>
10. Сонгогчдын нэрийн жагсаалт үйлдэх, сонгогч шилжих журам. УБЕГ. 2020 он.
<https://burtgel.gov.mn/post/43795>
11. СЕХ-ны 46 дугаар тогтоол. 2020 он.
<https://gec.gov.mn/>
12. Хяналтын тооллого хийх журмыг батлах тухай СЕХ-ны 22-р тогтоол.
https://gec.gov.mn/uploads/2020/tusul_juram/
13. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн эрх зүйн баримт бичгийн эмхэтгэл. 2020 он.
14. Төрөөс нээлттэй өгөгдлийн талаар баримтлах бодлогын чиглэл. 2019 он.
<https://cita.gov.mn/wp-content/uploads/2019/08/unnamed-file.pdf>
15. Нээлттэй өгөгдлийн тухай хуулийн төсөл. 2020 он.
16. Хүн амын статистикийн үндсэн үзүүлэлт тооцох аргачлал. 2013 он.
17. Ухаалаг засаг төсөл, Монгол улсын нээлттэй өгөгдлийн бэлэн байдлын үнэлгээ. 2018 он.
18. Монгол Улсын цахим өгөгдлийн орчны зураглал ба үнэлгээ. 2017 он.

19. “Монгол Улсын Их Хурлын сонгуулийн дүн” эмхэтгэл. 1992-2016 он.
20. “Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн” эмхэтгэл. 1993-2017 он.
21. “Статистикийн эмхэтгэл”. 2019 он.
22. OpenData Barometer, Leaders Edition. 2018 он.
23. OpenData Barometer, Global Report. 2017 он.
24. IDEA, Voter turnout around the world. 2015 он.
25. Монгол улс ерөнхийлөгчийн сонгууль 2013 оны 6-р сарын 26 өдөр ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль Ажиглах Хорооны Эцсийн тайлан.
<https://www.osce.org/files/f/documents/7/d/107203.pdf>
26. Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын их хурал болон орон нутгийн сонгуулийн хуулийн төсөлд өгөх АИХЭГ-ын санал Варшав хот. 2019 он.
<https://www.osce.org/mn/odhr/elections/mongolia/441041>
27. Монгол Улс ерөнхийлөгчийн сонгууль. 2017 оны 6-р сарын 26-н болон 7-р сарын 7-ны өдрүүд ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгууль ажиглах хязгаарлагдмал хорооны эцсийн тайлан
<https://www.osce.org/files/f/documents/1/3/366136.pdf>
28. Монгол улсын их хурлын сонгууль 2016 оны 6-р сарын 29-ний өдөр ЕАБХАБ-ын АИХЭГ-аас томилогдсон Сонгуулийн ажиглах хорооны Тайлан
<https://www.osce.org/files/f/documents/2/9/284941.pdf>
29. Монгол Улсын их хурлын сонгуулийн дүн (1992-2016 он).2017 он.
<https://www.gec.gov.mn/>
30. Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн дүн (1993-2017), Сонгуулийн ерөнхий хороо. 2017 он. <https://www.gec.gov.mn/>
31. Сонгуулийн ерөнхий хорооны мэдээ. 2020 оны 6 сарын 25-ны өдөр
<https://www.gec.gov.mn/blog/2862>
32. Хүн амын өсөлт, өөрчлөлт, хандлага. Үндэсний статистикийн хороо. УБ.,2007 он.
https://1212.mn/BookLibraryDownload.ashx?url=Dundaj_naslalt_and_ND.pdf&ln=Mn
33. Voter registration. ACE project
<https://aceproject.org/ace-en/topics/vr/vra/vra01>
34. Улсын Бүртгэлийн Ерөнхий Газар ямар ч буруугүй. УБЕГ-ын мэдээлэл. 2012-6-25
<http://www.assa.mn/a/3717>
35. Ардчилсан нам ард түмний саналыг хамгаалж чадсангүй. Өдрийн сонин. 2012.12.04.
<https://dnn.mn/archive/31666/>
36. Монгол Улсын Сонгуулийн ерөнхий хорооны албан ёсны цахим хуудас
<https://gec.gov.mn/>
37. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Улсын бүртгэлийн ерөнхий газрын албан ёсны цахим хуудас <https://burtgel.gov.mn/home>



38. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан.
www.1212.mn
39. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем
[https://www.legalinfo.mn/.](https://www.legalinfo.mn/)

UIH.MN
СУДАЛГААНЫ САН

UIH.MN
СУДАЛГААНЫ САН